

ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ТАЙЛАН



2023

APU COMPANY 100 YEARS
Absolute. Pure. Unique.

УДИРТГАЛ

Уриа үг
Эрхэм зорилго
Алсын хараа
Үнэт зүйлс
АПУ ХК-ийн тогтвортой хөгжлийн стратегийн танилцуулга
ТУЗ-ийн даргын захидал
Гүйцэтгэх захирлын захидал
НҮБ-ын тогтвортой Хөгжлийн Зорилт 2030 уялдаа холбоо

ЯМАГТ ОРШИХ ӨВ СОЁЛ

Асуулт, хариулт
Холбоотой тогтмол ажлууд, төсөл, хөтөлбөрүүд

НОГООН БА ЦЭВЭР ТУНГАЛАГ

Асуулт, хариулт
Холбоотой тогтмол ажлууд, төсөл, хөтөлбөрүүд

ХҮЧИРХЭГЖСЭН ХАМТ ОЛОН

Асуулт, хариулт
Холбоотой тогтмол ажлууд, төсөл, хөтөлбөрүүд


БАЯЛАГ БА ХАРИУЦЛАГАТАЙ

Асуулт, хариулт
Холбоотой тогтмол ажлууд, төсөл, хөтөлбөрүүд

ТОГТВОРТОЙ ТҮНШ

Асуулт, хариулт
Холбоотой тогтмол ажлууд, төсөл, хөтөлбөрүүд

ДАВТАГДАШГҮЙ СОЁЛ,
ҮНЭТ ӨВ



УРИА ҮГ / ORGANIZING IDEA

ҮРГЭЛЖ ӨӨДӨӨ
ALWAYS FORWARD



ЭРХЭМ ЗОРИЛГО / MISSION

ШИНЭ САНАЛ САНААЧИЛГА,
БҮТЭЭХ ТЭМҮҮЛЛЭЭР УРЛАЖ
БУЙ БҮХЭНДЭЭ ҮРГЭЛЖ
СЭТГЭЛЭЭ ШИНГЭЭНЭ.

TO CONTINUOUSLY INNOVATE,
CREATE, AND ENRICH, GUIDED BY
OUR INNER EXPLORING SPIRIT

АЛСЫН ХАРАА / VISION

ДЭЛХИЙД ТАНИГДАХ
ЭРХЭМ МОНГОЛ ХҮМҮҮНИЙ
ОЮУН ЧАДВАР, УР УХААН,
ШИНЭЧЛЭЛ, ТОГТВОРТОЙ
ХӨГЖЛИЙН УНДАРГА БАЙЯ.

TO BE THE PILLAR OF MONGOLIAN
EXCELLENCE IN CRAFTSMANSHIP,
INNOVATION, AND SUSTAINABLE
PRACTICES THAT INSPIRE THE
WORLD

АПУ компани түүхт 100 жилийн ойгоо тохиолдуулан олон улсын Publicis groupe зөвлөх үйлчилгээний агентлагтай хамтран алсын хараа, эрхэм зорилгоо шинэчлэн тодорхойлж, “Үргэлж Өөдөө” уриатайгаар шинэ зуунаа эхлүүлж байна.



ҮНЭТ ЗҮЙЛС / VALUES

CURIOSITY 	AUTHENTICITY 	CREATIVITY 	HUMANENESS
ТАНИХ ЭРМЭЛЗЭЛЧАНАР	ҮНЭН ЯЛЪЯ	БҮТЭЭЛЧ ЧАДВАР	ХҮНЛЭГ СЭТГЭЛ

ДАДАЛ ХЭВШИЛ / BEHAVIOURS

ЭРЭЛ, ХАЙГУУЛЧ СЭТГЭЭ EXPLORE	ХАМТДАА ЯЛЪЯ WIN	ИННОВАЦИЛАГ АЖИЛЛАЯ INNOVATE	ХҮНДЛЭН ЭРХЭМЛЭЭ CARE
Тасралтгүй шинийг эрэлхийлж, хуваалцаж, суралцаж, туршъя.	Чанарыг эрхэмлэж ялалтын сэтгэлгээгээр урагшилъя.	Уламжлалаа хүндэлж, шинийг бүтээе.	Хүн байхыг чухалчилж, сайн сайхныг түгээе.
Never stop exploring, Learn, share & re-apply	Never compromise on Quality	Embrace innovation & staying true to the roots	Think people first, deliver the goods

АПУ ХК-ИЙН ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН СТРАТЕГИЙН ТАНИЛЦУУЛГА

СТРАТЕГИЙН АЛСЫН ХАРАА:

АПУ ХК өөрийн урт хугацааны зорилготой уялдсан тогтвортой хөгжлийн нөлөөллөө цар хүрээ, төвлөрөх чиглэлийн хувьд нарийвчилж, хэмжигдэхүйц, оновчтой аргачлалаар хянах, үүнд тулгуурласан бизнес шийдвэрүүдийг гаргах үйл явцын зураг байх.

Өнгөрсөн 99 жилийн хугацаанд дотоод хамт олон болон харилцагч, хэрэглэгч, бэлтгэн нийлүүлэгчид, байгаль орчин зэрэг бүхий л гол оролцогч талуудын дэмжлэг, үр шимээр өнөөдрийн АПУ ХК бүтсэн билээ.

Зуун жилийн ойн босгон дээрээ бид 2023 онд бүх хамтрагчдадаа эргээд тогтвортой, найдвартай түнш нь байж, ижил итгэл үнэмшлийнхээ дагуу нэгдэж хамтран ажиллах гэж хичээсэн. Ирэх 100 жилдээ АПУ ХК эх дэлхий болон Монгол улсдаа ямар хөрөнгө оруулалт, үр нөлөө, үнэ цэнийг бүтээхээ зураглаж буйн хүрээнд бид бүхий л тогтвортой хөгжлийн ажлууд болон зорилтуудыг нэгтгэн системчилж 5 ханат нөлөөллийн гэр моделийн дагуу **"Бахархалт Монгол"** Тогтвортой хөгжлийн стратеги 2030-ын тэргүүлэх чиглэлүүдээ боловсрууллаа.



ТУЗ-ИЙН ДАРГЫН ЗАХИДАЛ

"Тогтвортой амьдралын хэв маяг, байгалийн хэмнэлтэй уялдан урагшлах аж ахуйн тухай ойлголт нь Монгол түмэнд шинэ ойлголт биш юм. Өнөө маргааш бус 9 үеэрээ өөрсдийн үл мөр, нөлөөллөө зураглаж ирсэн өвөг дээдэс маань холч ухаанд суурилсан "стратегийн мэргэжилтнүүд" байсан гэдэгт бид эргэлздэггүй. Монгол гэрийн дугуй бүтэц, Монгол гутлын хавтгай үл зэрэг нь бидэнд өвлөж ирсэн, байгаль эхдээ үл мөр үлдээхгүй, үргэлж хувьсаж буй амьдралын мөчлөгтэй уялдаж, урагшлах замыг заасан уламжлалт технологи гэж бид ойлгодог. Амьдралын зохистой хэв маягийг хэвшүүлэх энэхүү үнэт зааврыг бид эрхэмлэж, бүхий л үйл ажиллагаа, инновацдаа шингээн ирсэн. Цаашид ч энэ өв соёлыг хойч үедээ өвлүүлэн үлдээх нь зах зээлд томоохон байр суурь эзлэн, олон мянган ажилтан, хэрэглэгч, хамтрагчдын өдөр тутмын түнш байж, эергээр нөлөөлөх боломжийг атгалцаж буй бидний үүрэг юм.



Тийм ч учраас АПУ ХК-ийг нэг гэр гэж үзээд илүү ч биш дутуу ч бус, тус бүрнээ эн тэнцүү чухал үүрэгтэй 5 хана буюу 5 тэргүүлэх чиглэлтэйгээр зурагласан нь энэ юм. Дунд хугацаанд буюу 2030 он хүртэл бид бүх үйл ажиллагаагаа "Монгол бахархал байх"-д чиглүүлж, жинхэнэ Монгол мөн чанарыг бодит ажил, бизнесийн бодит шийдвэрүүдээр дэмжих суурийг бэхжүүлэхээр зорьж байна. Энэхүү аялалд АПУ ХК дангаараа биш өнөөдөр энэхүү тайланг уншиж буй та бүхэн хамтран замнах нь дамжиггүй юм. Өөрчлөлтийг өөрсдөөсөө эхэлж буй энэ аялалд хамтран урагшилж буй та бүхэндээ талархал илэрхийлье."

Пүрэвийн Батсайхан

Batsaikhan



Түүхэн 100 жилээ угтаж буй АПУ ХК нь ус ундаа, шар айраг, архи, сүүн бүтээгдэхүүний зах зээлд Монгол улсдаа тэргүүлэгч, ууган компаниудын нэг билээ. Бүх томоохон компаниудын нэгэн адил тогтвортой байдал, нийгэмд үзүүлэх эерэг нөлөөлөл нь бидний хувьд нэн чухал юм. Шингэн хүнс үйлдвэрлэгчийн хувьд бид зохистой хэрэглээг бүх чиг үүргийн ажлуудаараа дамжуулан таниулж, соёлыг түгээж ажилладаг. Аливаа тогтвортой хөгжлийн стратеги нь нэн тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэхэд үйл явцын тодорхой зорилт, хэмжүүрүүдийг агуулсан байх шаардлагатай байдаг. Тийм учир Тогтвортой хөгжил АПУ ХК-д яагаад чухал болох, бүх оролцогч талууд маань энэ үйл явцад бодит үүрэг оролцоотой байхыг таниулах шаардлага бидэнд үүссэн. Харин хэр үр дүнтэй, ойлгоход дөхөм, хүн бүрийн өдөр тутмын амьдралтай холбож, оролцогч тал бүрт үнэ цэнтэй, хамааралтай байдлаар хөрвүүлэх нь биднээс шалтгаалж байгаа тул “Бахархалт Монгол” Тогтвортой хөгжлийн стратегидаа нэгтгэн зураглалаа. АПУ ХК дэлхийн тавцанд Монгол улсыг төлөөлөхүйц бренд болох зорилттой. Үүнийг бодит ажил болгох, сайн сайхны төлөө атгасан гар шиг **“ҮРГЭЛЖ ӨӨДӨӨ”** урагшлахад дэмжиж, хамтын ирээдүйг бүтээлцэж буй АПУ гэр бүлийн гишүүд болон түншүүддээ талархал илэрхийлье.

Цэвээнжавын
ЭРДЭНЭБИЛЭГ



Нэгдсэн Үндэстний Байгууллагын “Тогтвортой Хөгжлийн Зорилгууд – 2030”-тай мөн уялдуулж стратегиа боловсруулж буй бөгөөд дараахь зорилтууд бидний үйл ажиллагаа, хүрээлэлтэй хамгийн өндөр хамааралтай.





Бид 2023 оны
Тогтвортой хөгжлийн
тайландаа стратегийн
5 хана буюу
тэргүүлэх 5 чиглэлд
гүйцэтгэсэн ажлуудаа
хүргэж байна, та
бүхэн хүлээн авна уу.





ЯМАГТ ОРШИХ ӨВ СОЁЛ

МОНГОЛ ӨВ СОЁЛ

Зорилго

Монгол үндэстний гайхамшигт өв соёлыг ямагт амьд байлгаж, хойч үедээ өвлүүлэн үлдээхэд АПУ ХК өөрийн бизнесийн практик, хамтын ажиллагаа, нөөц боломжоо бүрэн ашиглах болно.

ЯМАГТ ОРШИХ ӨВ СОЁЛ



Пүрэв
БАТСАЙХАН
ТУЗ-ийн Дарга

Асуулт:

АПУ ХК-ийн “Бахархалт Монгол” Тогтвортой хөгжлийн стратеги нь Монголын өв соёлыг хадгалахтай хэрхэн уялдаж байна вэ?

Хариулт:

Үндэсний баялаг өвийг хадгалах, хамгаалах, хойч үедээ өвлүүлэн үлдээхийн тулд АПУ ХК-ийн нөөц, инноваци, хамт олны сэтгэл, чадварыг энэ стратегийг хэрэгжүүлэхэд чиглүүлсэн байгаа. Малчид, сүү бэлтгэн нийлүүлэгчидтэй орон нутагт тогтвортой хамтран ажиллах, уламжлалт цагаан идээний соёлыг орчин үеийн үйлдвэрлэлтэй хослуулан боловсронгуй болгох чиглэл энэ стратегид багтсан. Үүний тулд сүү бэлтгэн нийлүүлэгчдийнхээ өдөр тутмын ажлын ачааллыг хөнгөвчлөх, стандартыг бий болгох, ингэснээр өрхийн тогтмол орлогыг дэмжих зэрэг ажлуудыг “Монгол сарлаг” төслийн хүрээнд хийж байна. Үүний зэрэгцээ улаан буудай, эмийн ургамал нийлүүлэгчдээс эхлээд АПУ ХК-ийн ажиллагсадын хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангахад чухал үүрэгтэй ажлын хувцас үйлдвэрлэгчид зэрэг дотоодын бизнесүүдтэй хамтран ажилласаар ирсэн.

АПУ ХК-ийн хэрэгжүүлж буй “Соёлоор Гоёно” хөтөлбөр нь Тогтвортой хөгжлийн стратегийн томьёололд тусгасанчлан Монгол түмэн, дотоодын бизнесүүд өөрсдийн дахин давтагдашгүй соёл, үнэт зүйлс, өвөөрөө бахархаж, үүн дээрээ тулгуурлан маргаашаа зураглахад сэдэл өгөх гол зорилготой. Энэ бүхэн нь Монгол хүний мөн чанарыг шингээсэн соёл, ёс заншлаа дараагийн үедээ хайрлан дамжуулахад хувь нэмрээ оруулах, Монгол бахархалыг бүтээх эрмэлзэл, хэв маяг, дадлыг харилцагчдынхаа өдөр тутмын амьдрал, харилцаа, сонголтод нөлөөллөөрөө хэвшүүлэх зорилттой стратегийн маань нэг томоохон чиглэл юм.

“Ямагт орших өв соёл” хананы буюу АПУ ХК-ийн Тогтвортой хөгжлийн стратегийн тэргүүлэх чиглэлийн нэг нь өв соёлоо хадгалж хамгаалах төдийгүй орчин үеийн амьдралд шингээж, хойч үедээ өвлүүлэн үлдээж, арвин их өв соёлоо олон жилийн турш амьд байлгахыг зорьж буйг онцолж байгаа билээ. Холбоотой ажлуудаа зураглан хүргэж байна.

Монгол үндэстний гайхамшигт өв соёлыг ямагт амьд байлгаж, хойч үедээ өвлүүлэн үлдээхэд АПУ ХК өөрийн бизнесийн практик, хамтын ажиллагаа, нөөц боломжоо бүрэн ашиглах болно.

ҮНДЭСНИЙ ИХ ӨВ СОЁЛООР ГОЁНО

АПУ ХК нь үндэсний бөхийн спортыг дэмжих замаар өв соёлоо сурталчилж, Монгол Улсын Арслан Б. Орхонбаяр, Монгол Улсын Харцага Т. Өсөх-Ирээдүй нартай урт хугацаанд хамтран ажиллахаар боллоо. Бид уламжлал, өв соёлоо эрхэмлэн дээдэлж үндэсний спортууд болох шагайн харваа, сур харваа, хурдан морь, үндэсний бөх тэргүүтэй олон төрөлд бахархал болсон тэргүүлэх тамирчидтай тогтмол хамтран ажилласаар ирсэн. Эдгээр тамирчдыг дэмжин ажиллах нь бидний хувьд хувь хүний амжилтаас илүүтэй эдгээр үндэсний спортоор дамжин олон зууны турш өвлөж ирсэн хат, тэвчээр, уужим ухаан, олон нүүдлийг харж хөдлөх монгол чанарыг хадгалах, дэвжээх мэрийлт юм.

1400 ЖИЛИЙН НАСТАЙ АЛТАЙН ЯТГА

Монгол түмний хамгийн эртний хөгжмийн зэмсгүүдийн нэг болох 1400 жилийн настай, соёлын гайхамшиг болсон Алтайн ятгыг өвлүүлэн үлдээх зорилгоор олон нийтэд таниулах ажлыг “Соёлоор Гоёно” хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүллээ.

Энэхүү хөгжмийн зэмсгийг мэргэжлийн урлаач, СТА Д.Ганпүрэвээр урлуулж “Өнөр бүл” асрамжийн газрын хүүхдүүдэд хандивласан. Энэ нь тус хөгжмийн зэмсгийг сонирхон суралцах дараагийн үеийг бэлдэх эхний алхам юм. Алтайн ятгын уянгалаг аялгууг уртын дуу, орчин үеийн Регги урлагтай холбон үр хойчдоо өвлүүлэхээр Алтайн ятгын талаар нэвтрүүлэг, “ТААТАЙ ЯА” дууг мөн бүтээж олон нийтийн сонорт хүргэсэн. Үндэсний урлагийг өнөө цагийн өдөр тутмын амьдрал, сонголтод нийцүүлэн ойртуулж, хүртээмжийг сайжруулах нь тэр чинээгээрээ өв соёлыг хадгалах, урт хугацаанд он цагаас үл хамааран мөнхөд амьдруулах нэг арга гэж бид итгэдэг.



МОНГОЛ САРЛАГИЙН ШИМТ БҮТЭЭГДЭХҮҮНҮҮД MONT-YAK

Шилжилтийн үеийн органик хүнс



Уламжлал, өв соёлоо орчин үеийн дэвшилтэт технологитой хослуулсан бүтээмжид суурилсан хөдөлмөр хөнгөвчлөх технологийг нэвтрүүлэх замаар сүү, сүүн бүтээгдэхүүний чанарыг нэмэгдүүлэх, малчдыг тогтмол орлоготой болгоход хувь нэмрээ оруулах зорилготойгоор “Гэр Үйлдвэрлэл” төслийг 2022 онд санаачлан хэрэгжүүлж эхэлсэн. Улмаар сарлагийн мал аж ахуй эрхлэлт, түүний онцлог шинж чанар, өрхийн үйлдвэрлэлийн боломжийг үнэлэх, саалийн гарц чанарыг нэмэгдүүлэх, малчдын хөдөлмөр хөнгөвчлөх зорилгоор “Сарлагийн саалтуур” төслийн ТЭЗҮ боловсруулж хэрэгжүүлсэн. Архангай аймгийн Чулуут суманд хэрэгжиж буй “Монгол сарлаг” хөтөлбөрийг 30 өрхийг хамруулан “Гэр үйлдвэрлэл”-ийн загвараар, орон нутагт нэмүү өртөг шингээн хэрэгжүүлж байна. Төслийн гол онцлог нь хуванцар савны хэрэглээг 100% халж, чанар стандартын шаардлага хангасан түүхий эдээр бэлтгэн нийлүүлэхэд оршиж байна.

Ийнхүү Mont-Yak брэндийн 9 нэр төрөл бүхий сарлагийн сүүн бүтээгдэхүүнийг хэрэглэгчдийн гарт хүргэж эхэллээ. Сүү бэлтгэх анхан шатнаас эцсийн бүтээгдэхүүн хүртэлх бүхий л дамжлагыг стандартжуулж органик хүнсний шаардлагыг ханган хайлмаг болон шар тосон дээр ШИЛЖИЛТИЙН ҮЕИЙН ОРГАНИК ХҮНС гэрчилгээг гардан авч тухайн нэр төрөлдөө анх удаагаа малчидтай хамтран органик хүнсний гэрчилгээ хүртсэн үйлдвэрлэл болж байна.



МОНГОЛ БЯСЛАГ, ШИГҮДЭРИ УРЛАХ ШИНЭ ҮЙЛДВЭР

Сэлэнгэ аймгийн Мандал суманд АПУ ХК-ийн Спирт Бал Бурам ХХК 50 дахь жилдээ үйл ажиллагаа явуулж буй бөгөөд энэхүү 50 жилийн ойн босгон дээр Монгол улсдаа хүчин чадлаараа хамгийн томд тооцогдох Европын Холбооны стандартыг бүрэн хангасан байгаль орчинд ээлтэй тоног төхөөрөмжөөр бүрэн тоноглогдсон шинэ үйлдвэрээ ашиглалтад орууллаа.

2016 оноос хойш хийсэн судалгаанд Монгол улсад нийт 3000 тонн буюу нийт 102 тэрбум төгрөгийн бяслагийг гаднын улс орнуудаас импортоор оруулж ирдэг бөгөөд тэдгээр импортын бяслагийн дийлэнх нь дуураймал буюу аналог бяслаг байдаг төдийгүй сүүний орц бага, хүнсний нэмэлт бүтээгдэхүүн ихээр ашиглагдсан байдаг. Тиймээс бид Голланд, Швейцар, Англи улсын бяслаг үйлдвэрлэх аргачлалуудаас Монгол үнээний сүүнд тохирох бяслаг үйлдвэрлэлийн технологийг нутагшуулан ийнхүү шинэ үйлдвэрээ байгууллаа.

Нийт импортолдог бяслагийн 10 орчим хувийг эх орондоо үйлдвэрлэх, үйлдвэрлэлийн хоёрдогч түүхий эдийг боловсруулан, дээд зэрэглэлийн альбумин уураг, сүүний сархад үйлдвэрлэх төдийгүй сүүний усыг дангаар нь ялган авч үйлдвэрлэлд ашиглах, гадна агаарын хүйтнийг нөөцлөн хөргөлтийн төхөөрөмжийн ачааллыг тэнцвэржүүлж, эрчим хүчний хэрэглээг бууруулах боломжтой, техник, технологийн орчин үеийн шийдэл бүхий цогц үйлдвэр юм. Сэлэнгэ аймгийн Мандал сум, Зүүнхараагийн орон нутгийн малчдаас 620 орчим тонн сүү хүлээн авч 62 тонн бяслаг, 11 мянган литр Шигүдэри сархдын архи үйлдвэрлэн, зах зээлд Хонин нуга брэндийн Чеддар, Гоуда, Моццарэлла бяслаг, Шигүдэри брэндийн 500мл, 750мл-ийн савлагаатай бага хатуулагтай сүүний сархдыг борлуулалтад нэвтрүүлэн худалдаалж байна. Мөн 2023 онд Хонин нуга, Шигүдэри брэнд нь Стандарт, хэмжил зүйн газраас БАТАЛГААЖСАН тэмдэг, бүтээгдэхүүний тохирлын гэрчилгээгээ гардан авлаа.



ТАНЫ ӨДӨРТ ХЭРЭГЛЭХ ЁСТОЙ

ЦАГААН ИДЭЭНИЙ ХЭМЖЭЭ:



1АЯГА СҮҮ

200ГР



УУРАГЛАГ ЦАГААН ИДЭЭ (БЯСЛАГ, ДАРУУЛ, ЭЭЗГИЙ)

70ГР



1АЯГА ТАРАГ

180ГР



ТОСЛОГ ЦАГААН ИДЭЭ (ЗӨӨХИЙ, ӨРӨМ, ЦЭЦГИЙН ТОС, ШАР ТОС)

50ГР



Та өдөр бүр 500гр сүү, сүүн бүтээгдэхүүн хэрэглэж цагаан хувьсгалд нэгдээрэй.

ДЭЛХИЙН СҮҮНИЙ ӨДӨР

“Дэлхийн сүүний өдөр” болон “Олон Улсын Хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг” АПУ Дэйри ХХК жил бүр хэрэглэгчдийн хамтаар онцгойлон тэмдэглэн өнгөрүүлдэг. 2023 онд Сүхбаатарын талбай, Шангри-Ла худалдааны төв, Үндэсний цэцэрлэгт хүрээлэн гэсэн гурван байршилд сүүний ашиг шимийг таниулсан арга хэмжээг зохион байгууллаа. Ингэснээр сүүний талаарх мэдлэгийг олон нийтийн дунд зөвөөр, хүртээмжтэйгээр хүргэх, Монгол улсын уур амьсгалд нийцсэн тэнцвэртэй хооллолт, эрүүл амьдралын хэв маягийг эрхэмлэх, дадал болгоход сүүний ач холбогдлыг таниулахад түлхэц болсон.



APU DAIRY
МОНГОЛ СҮҮНИЙ ҮЙЛДВЭР

APU DAIRY
МОНГОЛ СҮҮНИЙ ҮЙЛДВЭР



СҮҮ БОЛ УУРГИЙН ГАЙХАЛТАЙ ЭХ ҮҮСВЭР ЮМ.

Your Friend and 74K others 15K Commen

ДОТООД НИЙЛҮҮЛЭГЧДИЙГ ДЭМЖИЖ БУЙ ҮЙЛ АЖИЛЛАГАА

АПУ ХК-ийн бэлтгэн нийлүүлэгчдийн 75 хувийг дотоодын бэлтгэн нийлүүлэгч нар эзэлдэг бөгөөд бид урт хугацаанд найдвартай бизнесийн хамтрагч байж бизнесийн өсөлт хөгжилтэнд хувь нэмрээ оруулан ирээдүйн үнэ цэнийг бүтээлцэн ажиллаж байна. Эх орны хөрсөнд тарьж ургуулсан шилмэл сортын улаанбуудайг Булган, Сэлэнгэ, Дархан, Төв, Эрдэнэт, Архангай, Өвөрхангай, Хөвсгөл, Увс, Хэнтий аймгуудын 70 гаруй тариаланчдаас худалдан авч үйлдвэрийн хэрэгцээг 100% хангаж дээд зэргийн спиртийг чанарын өндөр түвшинд Герман техник технологиор үйлдвэрлэж байна.

САВ БАГЛАА БООДЛЫН ХУДАЛДАН АВАЛТ

Үйлдвэрийн сав баглаа боодол болох хуванцар сав бэлдэцийг 2012 оноос хойш тасралтгүй 12 жилийн хугацаанд Цэц Зам Пласт ХХК-аас, бүх төрлийн цаасан хайрцагыг Гофро ХХК нь 2011 оноос нийлүүлж байгаа. Мөн багцлагч гялгар уутыг Мультипак ХХК-аас сүүлийн 15 жилийн хугацаанд тасралтгүй худалдан авч байна. Ус ундааны бүх төрлийн шошгыг Царамтай Арвай ХХК-ийг анх үүсгэн байгуулагдахад нь буюу 2019 оноос хойш худалдан авч манай компанийн шаардлага хүсэлтийн дагуу орчин үеийн тоног төхөөрөмжтэй болж, Монголдоо анх удаа 9 өнгөөр хэвлэх машиныг худалдан авч суурилуун ажиллаж байгаа.

ХӨДӨЛМӨР ХАМГААЛЛЫН ХУВЦАС ХЭРЭГСЭЛ

Дотоодын үйлдвэрлэгчдийг дэмжих, олон улсын S1, S3 стандартшаардлагыг хангасан бүтээгдэхүүн нийлүүлэх гэрээг Бест Шөүс ХХК болон Өүлэн мэнч ХХК-тай байгуулснаар жилдээ 2,700 хос хөдөлмөр хамгааллын гутал, 2,300 ширхэг хөдөлмөр хамгааллын хувцсыг хувалдан авч хамтран ажиллаж байна.

ОЛОН УЛСАД МОНГОЛ СОЁЛЫГ ТҮГЭЭХ НЬ

АПУ ХК экспортын үйл ажиллагааны хүрээгээ тэлж 4 тивийн 9 улс оронд борлуулалтаа хийж байна. 2023 оны хувьд Казакстан, Итали, Швейцарь, улсын зах зээлд шинээр нэвтэрсэн байна. Олон улсын худалдааны газар нь Брэнд бүтээгдэхүүнээ дэлхийн хэрэглэгчдэд хүргэхийн хажуугаар Монгол Улсаа, уламжлал, өв соёлоо, идээ ундааных нь соёлын хамт Брэнд бүтээгдэхүүнээ дэлхийд таниулах үйл ажиллагаагаа хэрэгжүүлсээр байна.

Онцлох үйл явдлууд:

- Төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг сайжруулах, Монгол улсын соёлыг түгээх үйлсэд манлайлан оролцож Тайланд, АНУ, Канадын элчин сайдын яамдуудтай хамтран ажиллалаа.
- Европын зах зээлийн харилцагч, хэрэглэгчидтэйгээ илүү ойр ажиллах, бүтээгдэхүүнээ аль ч зах зээлээс худалдан авах боломжийг бүрдүүлэх зорилгоор Нидерланд улсын Роттердам хотод Олон улсын агуулах тээвэр түгээлтийн компанитай хамтарч эхлэв.
- www.chinggiskhan.com сайтаар дамжуулан брэнд бүтээгдэхүүнээ АНУ-д худалдаалж эхлэв.
- Олон Улсын Үзэсгэлэнд Брэнд бүтээгдэхүүнүүдээ танилцууллаа: China International Import Expo; Bazar Berlin 2023; The 4th China-Mongolia Expo.
- Олон улсын шингэн хүнсний мэргэжлийн сэтгүүлүүд Монгол Брэнд бүтээгдэхүүнийг онцлон бичсэн байна: The Spirit Business; Robb Report Thailand

МАЛЧИД, ФЕРМЕРҮҮДИЙН АМЬЖИРГААГ ДЭМЖИХ

АПУ Дэйри Монгол сүүний үйлдвэр нь малчид, фермерүүдийн тогтвортой амьжиргааг дэмжих хүрээнд цаг уурын онцгой нөхцөл байдал, өвөлжилт хүндэрсэн цаг үед шингэн сүүг өндөр үнээр авч, нэн шаардлагатай байгаа 150 гаруй тонн малын тэжээлээр хангасан.



“НОГООН ДАДАЛТ МАЛЧИД” МЭДЛЭГЖИХ АЯН



Хүнсний аюулгүй байдал, хангамжийг тогтолцоогоор нь сайжруулах үндэсний хөдөлгөөний хүрээнд “Ногоон Дадалт Малчид” мэдлэгжих аяныг эхлүүллээ.

Стратегийн онцгой хүнс болсон сүүний чанар, АПУ ХК-ийн сүү бэлтгэн нийлүүлэлтийг түүчээлэн ажиллаж буй Зүүнхараа дахь малчид маань аяны эхний арга хэмжээнд оролцсон. Ингэснээр анхан шатны үйлдвэрлэгч буюу малчид болон сүү бэлтгэн нийлүүлэгч фермерүүдийн дунд Хөдөө аж ахуйн зохистой дадлыг хэвшүүлэх, баталгаажсан органик Монгол хүнс бэлтгэх ойл ажиллагааг мэргэжлийн байгууллагуудтай хамтран танилцуулж, өрхийн санхүүгийн боловсрол, малчдад чиглэсэн санхүүгийн хүртээмжийг цахим платформуудаар дамжуулан ойртуулах зэрэг салбарын цаг үеийн боломж, хандлагыг хэрэгжүүлэн ажиллахаар зорьж байна.

2024 онд тус төслийн оролцогч өрхүүд “Ногоон Дадалт Малчид” мэдлэгжих аянд нэгдэх юм.





НОГОООН, ЦЭВЭР ТУНГАЛДАГ БАЙГАЛЬ ОРЧИНД ДАХЬ УЛ МӨР

Зорилго

Эх дэлхий, байгаль орчинд үлдээж буй ул мөрөө багасгахын тулд сэтгэлгээний хэвшмэл хязгаарыг давж, сэтгэл зүтгэл гарган, өвөг дээдсийнхээ хадгалан үлдээсэн байгаль экологийн тэнцвэрийг идэвхтэй хамгаална.



НОГООН БА ЦЭВЭР ТУНГАЛАГ



Добрев
НИКОЛАЙ

Үйлдвэрлэл, үйл ажиллагаа
эрхэлсэн захирал

Асуулт:

АПУ компани нь байгаль орчны тогтвортой байдлыг дэмжих чиглэлээр ямар тодорхой санаачилга гаргаж байна вэ?

Хариулт:

АПУ нь байгаль орчинд үзүүлэх нөлөөллөө багасгахын тулд байгалийн нөөцийг ашиглаж буй үйлдвэрлэлийн процессын бүтээмжийг оновчлох, үр ашиггүй үйл ажиллагааг ямагт хамгийн бага хэмжээнд барихын төлөө тогтмол хянаж, сайжруулж ажилладаг. Эрчим хүчний хэмнэлттэй технологид хөрөнгө оруулалт хийж, хүлэмжийн хийн ялгарлаа бууруулахын тулд тээвэр болон бусад ложистикийг оновчилж, жил тутам үйлдвэрлэлд ашиглах усны хэрэглээг багасгаж ажиллаж байгаа нь хамт олны маань үе шаттайгаар хэрэгжүүлж буй олон арван ажлын нэгээхэн л хэсэг нь юм. Эдгээр ул мөрөө багасгах зорилтуудыг бодитоор дэмжих томоохон төслүүдэд бид мөн хөрөнгө оруулж, түүнийгээ дагасан ажлын байр, шинэ ур чадвар, боломжуудыг бий болгон ажилласаар байна. Жишээ нь, 2023 онд АПУ ХК-ийн Үйлдвэрийн хаягдал ус боловсруулах байгууламжийн төслийн ерөнхий концепц, дизайн боловсруулах ажил дуусаж, 2.8км шугам хоолойг татсан. Ус дахин ашиглах стандартын дагуу хийгдэх энэ байгууламж маань ашиглалтад орсноор цаашид АПУ ХК-ийн цэвэр усны хэрэглээгээ бууруулж, саарал усны ашиглалтаа нэмэгдүүлэх бодит боломж, хүчин чадал үүсэж байна.

АПУ ХК-ийн зүгээс өөрийн мянга мянган ажилтан, харилцагч, хэрэглэгч, бүх хамтрагч нар, тэдний цаана байгаа үр хүүхэд, хойч үед үлдээж болох хамгийн том өв бол байгаль орчноо тэнцвэртэй, эрүүл байлгахад зорьж хийж байгаа ажлууд маань болов уу гэж би итгэдэг.

“Ногоон ба цэвэр тунгалаг” хананы хүрээнд АПУ ХК нь эх дэлхий дээрх ул мөрөө багасгаж, тэнцвэртэй байгаль орчныг цогцлоохын тулд дотоод үйл явц, үйлдвэрлэлээ оновчлохын зэрэгцээ бусад байгууллагууд, залуу үеийг сэдэлжүүлэх ажлуудад 2023 онд ач холбогдол өгч ажиллалаа.


Эх дэлхий, байгаль орчинд үлдээж буй ул мөрөө багасгахын тулд сэтгэлгээний хэвшмэл хязгаарыг давж, сэтгэл зүтгэл гарган, өвөг дээдсийнхээ хадгалан үлдээсэн байгаль экологийн тэнцвэрийг идэвхтэй хамгаална.

УС – ЧАНДМАНЬ ЭРДЭНЭ

ҮЙЛДВЭРИЙН ХАЯГДАЛ УС БОЛОВСРУУЛАХ БАЙГУУЛАМЖ БАРИХ ТӨСӨЛ

АПУ ХК нь Үйлдвэрийн хаягдал ус боловсруулах байгууламж барих төслийг 2021 онд эхлүүлснээс хойш нэлээдгүй ажлуудыг хийж гүйцэтгэсэн. 2023 онд төслийн ерөнхий концепц дизайн боловсруулах ажилд зөвлөх компаниар Австралийн ВЕСА компанитай хамтран ажиллаж, төслийн барилга угсралт болон тоног төхөөрөмж нийлүүлэх, угсрах, суурилуулах олон улсын тендерийн бичиг баримт боловсруулж зарлах бэлтгэл ажлуудыг гүйцэтгэж байна. Тус ажилд зөвлөхөөр хуулийн ферм Легал Линк ХХК болон барилга угсралтын SD Development ХХК компаниудтай хамтран ажилласан.

Төслийн хүрээнд АПУ ХК-ийн үйлдвэрүүд, АПУ Дэйри ХХК-ийн үйлдвэрийн хаягдал усыг цуглуулах насос станцад төвлөрүүлэх бөгөөд насос станцад цугласан хаягдал усыг цэвэрлэх байгууламж руу хүргэх 2.8 км шугам хоолойн угсралтын ажлыг Нишин Илч ХХК болон Стандарт Хийт ХХК-нууд хийж гүйцэтгэх ажлыг эхлүүлээд байгаа нь 2024 онд барилга угсралтын ажлаар үргэлжлэх юм. АПУ ХК Үйлдвэрийн хаягдал усаа боловсруулах байгууламжийг ашиглалтад оруулснаар дахин ашиглах саарал ус гарган авч компанийн дотоод хэрэгцээг хангахаас гадна бусад хэрэглэгчдэд түгээх замаар гүний ундны усны хэрэглээг бууруулах бодитой ажил болох юм. Үүгээр зогсохгүй УБ хотын Төв цэвэрлэх байгууламжийн ачааллыг багасгах, Туул голын бохирдлыг бууруулах зэрэг урт хугацааны өндөр ач холбогдолтой төсөл юм.



ISO СТАНДАРТУУДЫН ТОГТМОЛ БАТАЛГААЖУУЛАЛТ

АПУ ХК нь үйлдвэрлэлээс гарч буй хаягдал усны стандарт шаардлагыг хангуулах хяналтын итгэмжлэгдсэн лабораторитой Монгол улсын анхны хүнс үйлдвэрлэгч компани боллоо. Үйлдвэрлэлээс гарч буй хаягдал усыг цэвэршүүлэх төслийн ажлыг эхлүүлсэн ажлын хүрээнд энэхүү усны хяналтын лабораторийг байгуулсан. Энд “Усны чанар, Ариутгах татуургын сүлжээнд нийлүүлэх хаягдал усны Ерөнхий шаардлага - MNS 6561:2015” стандартад 9 үзүүлэлтийг тодорхойлдог ба “Сорилтын болон шалгалт тохируулгын лабораторийн чадавхад тавигдах ерөнхий шаардлага “MNS ISO 17025” стандартаар анх удаа итгэмжлэгдсэн нь энэ юм.

Мөн Женевт төвтэй ISO стандартын олон улсын гэрчилгээжилтийн SGS компаниар ISO 14001:2015 Байгаль орчны менежментийн тогтолцоо стандартын аудит хийлгэн сертификатаа гардаж авсан. Жил жилийн үйл ажиллагааны чанараа бид ийнхүү тогтмол баталгаажуулсаар байна.



СААРАЛ УСНЫ ДАХИН АШИГЛАЛТ

Гол усаа дагаж нутагладаг Монгол түмэнд юугаар ч орлуулшгүй чандмань эрдэнэ бол ус байсаар ирсэн. АПУ ХК саарал усаа дахин ашиглах, хэмнэх байдлаар дахин сэргэх боломжгүй гүний усны хэрэглээгээ багасгасаар байгаа юм.

Усны шүүлтийн систем болон савлах үйлдвэрийн зайлсан усыг эргүүлэн ашиглах замаар 2023 онд бид нийт 15,056 м3 саарал усыг дахин ашигласан байна. Энэ нь 150,000 авто машиныг угаахтай тэнцэх хэмжээний ус бөгөөд жил бүр дунджаар 12 орчим хувиар усны дахин ашиглалтаа нэмэгдүүлдэг. Хаягдал усыг дахин ашиглах эх үүсвэр дээр нь үйлдвэрийн тоног төхөөрөмжөөс хаягдаж буй усыг тооцдог. Улаанбаатар хотын ногоон байгууламжийн усалгаа, угаалга, ариутгал зэрэгт саарал ус ашиглагдаж байгаа ба үйлдвэрийн цехийн анхан шатны угаалга цэвэрлэгээ, ариун цэврийн өрөөний ус татах зэрэгт мөн ашиглаж байна.



БАЙГАЛЬ ОРЧНЫ ТЭМДЭГЛЭЛТ ӨДРҮҮД

АПУ ХК нь “Дэлхийн Усны өдөр 2023”-ыг тохиолдуулан Эко Орчин ХХК, Мултипак ХХК, “Бичил нахиа”, “Хаягдал хувцсаа үнэ цэнэ болгоё” төслийн багтай хамтран “Эх Дэлхийгээ Хайрлаж, Усаа хэмнэе!” өдөрлөгийг нийт компанийн ажилтнуудын дунд уламжлал ёсоор зохион байгууллаа.

Өдөрлөгийн үеэр нийт хамт олноороо “Тогтвортой хөгжлийн зорилтууд”-ад хүрэхийн төлөө цэвэр усны эх үүсвэрийг хайрлан хамгаалах, нөөцийг зүй зохистой ашиглах, хэмнэх, усыг дахин ашиглах үүднээс нэгж бүтээгдэхүүнд зарцуулагдах усны хэрэглээг бууруулахад чиглэсэн бодлогыг танилцуулж, мэдээллийг хүргэсэн. Мөн Монгол улсын хүрээлэн буй орчны тулгамдсан асуудал ба гарц, хөрсөн бүрхэвчийн суурь ойлголт, эрүүл ахуйн ач холбогдол, бохирдлоос урьдчилан сэргийлэх арга хэмжээний талаар илтгэл, хэлэлцүүлэг хийж, танилцуулснаар хамт олны мэдлэгийг өдөр тутмын амьдралд хэрэгжүүлж болох ногоон дадлуудтай холбох боломж болж өгсөн юм. Тус өдөр нь АПУ ХК-ийн хувьд жил бүр тэмдэглэж, үйлдвэрлэлийн усны хэрэглээ, хэмнэлтийн ажлууд, зохистой дадал, боломжуудаа нэгдэн ярилцдаг тогтмол арга хэмжээ юм.



WORLD ENVIRONMENTAL DAYS
20-22 MARCH 2023
ДЭЛХИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ ТЭМДЭГЛЭЛТ ӨДРҮҮД

APU COMPANY
Absolute. Pure. Unique.



“ХАТАН ТУУЛ ГОЛОО ХАМТДАА ЦЭВЭРЛЭЭ”

АПУ ХК-ийн охин компани М Би Си Азиа Пасифик ХХК-ийн хамт олон “Хатан Туул голоо хамтдаа цэвэрлэе” үйл ажиллагааг өөрсдийн санаачилгаар зохион байгуулж, Гачууртын эцсээс Монгол шилтгээн хүртэлх нийт 2.5 км Туул голын эргийн ай сав газрыг цэвэрлэсэн. Тус үйл ажиллагааг хог хаягдлыг багасгахад олон нийтийг уриалах, ажилтнуудын идэвх оролцоог нэмэгдүүлэх зорилготойгоор жил бүр зохион байгуулдаг бөгөөд нийт 42 ажилтан оролцож, 30 шуудай хог хаягдлыг цуглуулан Баянзүрх дүүргийн хот тохижилтын компанид хүлээлгэн өгсөн юм.



ҮЕРИЙН ҮЕИЙН ТУСЛАМЖ



Их баяр Наадмын үеэр их хэмжээгээр орсон борооны улмаас үер усны гамшиг нүүрлэхэд Онцгой комисс, Цагдаагийн байгууллагын бие бүрэлдэхүүн болон гамшгийн бүсэд нэгдэн ажиллаж буй аж ахуй нэгжүүдэд зориулан Шунхлай Группийн харьяа компаниуд нэгдэж нийт 200 сая төгрөгийн шатахуун, халуун хоол, цэвэр ус, дархлаа дэмжих сүүн бүтээгдэхүүн, хөдөлмөр хамгааллын хувцас хэрэглэл, ариутгалын спирт зэрэг бусад эд материалын дэмжлэг үзүүлэн ажилласан. Мөн нийт аж ахуй нэгж, иргэд олон нийтэд сонор сэрэмж өндөр байж, гамшгийн нөхцөл байдлын эсрэг шуурхай арга хэмжээ аван, бүхий л хүчин чармайлтаа нэгтгэн ажиллахыг уриалан ажиллалаа. АПУ ХК-ийн охин компани СББ ХХК Сэлэнгэ аймгийн Мандал суманд буусан үерийн нөхцөл байдлыг даван туулахад зориулан мөнгөн тусламж, бүтээгдэхүүн, ажиллах хүн хүчээр мөн Мандал сумын онцгой комисст дэмжлэг үзүүлэн, хамтраад байна.

НОГООН БА ЦЭВЭР ТУНГАЛАА



ИРЭЭДҮЙН ЭЗДИЙН ШИЙДЭЛ: ХОГ ХАЯГДЛЫН ЗАСАГЛАЛ

ХҮҮХЭД ЗАЛУУСЫН НОГООН ДЭЛХИЙН ЗУРАГЛАЛ



Байгальд ээлтэй хэрэглээ, дадлыг дэмжих зорилгоор “Байгальд биш байх ёстой газар нь” гар зургийн уралдаан болон Reel & Tik Tok тэмцээнийг багачууд, залуусын дунд зохион байгууллаа. Уралдаанд оролцогчид маань өөрсдийн бий болгохыг хүсдэг төсөөллөө дүрслэн харуулахдаа тогтвортой байдал, өөрсдийнхөө байгаль орчин дахь нөлөөллөө улам гүнзгий ойлгох сэдэл болсон хэмээн найдаж байна. Уралдаанд оролцогчид маань бүтээлч байдлаа ашиглан эх дэлхийгээ хамгаалж, хайрлахын ач тусыг өөрсдөдөө ойр, хүлээж авахад сонирхолтой байдлаар хүргэсэн билээ. Зургийн уралдааны бүтээлүүдийн дээжийг сонирхоно уу.



БАЙГАЛЬД БИШ БАЙХ ЁСТОЙ ГАЗАР НЬ



ШИЙДЭЛД ТӨВЛӨРСӨН ЗАЛУУСЫН МЭТГЭЛЦЭЭН

Эх дэлхийгээ хайрлах, аливаа сөрөг нөлөөллүүдийг хязгаарлах тогтвортой хөгжлийн ажлуудыг хамтран хэрэгжүүлэхэд залуусын оролцоо, мэдлэг хамгаас чухал тул бид 2023 онд хүүхэд, залуусын дуу хоолойг өргөх, дэмжих ажлуудад төвлөрсөн.

Оюуны хөгжлийн Гэрэгэ клуб 20 жилийн ойгоо угтаж Тогтвортой хөгжлийн асуудлуудын шийдлийг хэлэлцэх парламентын мэтгэлцээнийг зохион байгуулсанд АПУ ХК дэмжин оролцсон. Оролцогч багууд Улаанбаатар хотын хатуу хог хаягдлыг ангилан ялгаж, дахин ашиглах тогтолцоог төр болон хувийн хэвшил хамтран хөгжүүлэх, эдийн засгийн төвлөрлийг орон нутаг руу чиглүүлэх зэрэг чухал сэдвүүдээр мэтгэлцэж байлаа.

Бид үйл ажиллагаандаа залуусыг илүү татан оролцуулж, шийдэлд чиглэсэн хэлэлцүүлгийг дэмжих, дуу хоолойг өргөхөд цаашдаа ч идэвхтэй оролцоор байх юм.



СУРАГЧДЫГ МЭДЛЭГЖҮҮЛЭХ НҮБ-ЫН ЗАГВАР ХУРАЛДААН

Монгол төдийгүй дэлхийн иргэд болж хөгжих ЕБС-ийн сурагчид НҮБ-ын Загвар хуралдаанаар дамжуулан жил бүр дэлхий нийтэд тулгамдаж буй асуудлуудыг хөндөн хэлэлцдэг энэхүү арга хэмжээг АПУ ХК дэмжин ажилласандаа баяртай байна. Энэ загвар хуралдаан нь НҮБ-ын жинхэнэ хуралдааны агуулга, дэг, хэлэлцдэг асуудлуудыг залуусын оролцоон дээр тулгуурлан явуулдаг бөгөөд Монголд 2015 оноос тасралтгүй зохион байгуулагдаж байна.

Оролцогчид олон улсын харилцаа, дэлхийн асуудлуудыг хоорондоо ярилцаж, нэгдсэн зөвшилцөл хийх, цаашлаад шийдэлд хүрэхийн төлөө мэтгэлцдэг. Энэ хуралдаанд оролцсоноор сурагчид олон улсын харилцаа, улс төрийн ойлголтоо нэмэх, дипломат ёсны тухай мэдлэгтэй болж, хэлэлцээрийн чухал чадварыг өөрийн биеэр мэдрэн суралцах боломжтой болдог.

ХӨВСГӨЛ НУУРЫГ ЦЭВЭРЛЭХ АВТОМАШИН

Khovsgol
Lake
National Park
Хөвсгөл
нуурын
байгалийн
цогцолбор

Хөвсгөл Нуур



Хөвсгөл нуур орчимд цуглардаг эзэнгүй хог хаягдлыг 20 жилийн турш цэвэрлэж, ангилан ялгаж яваа “Хогийн Сайнаа” хочтой ‘Хүн байгаль бүлэг’-ийн ахлагч Ж.Сайнбаяртай бид баяртайгаар хамтран ажилласан. Тэрээр “Овоонд өргөдөг мөнгөө Хөвсгөл нуурыг цэвэрлэх автомашин авахад зарцуулъя” хэмээн уриалж, хандивын аян эхлүүлсэн. Ангилсан хогийг ачих автомашин авахад шаардлагатай байсан 25 сая төгрөгийн 13 сая төгрөгийг АПУ ХК хандивлаж, иргэдийн санаачлагаар хийж буй олон нөлөөллийн ажлын төлөөллийг дэмжсэндээ баяртай байна. Бусад иргэд, аж ахуй нэгжийн өгсөн хандивыг нийлүүлэн бүрдүүлж Сайнаа гуай “ЗИЛ-130” автомашинаа худалдан авч Хөвсгөл нуур орчим болон Даян дээрхийн агуй цэвэр, хоггүй байх ажлыг идэвхтэй хийж, зочилж яваа хүмүүсд буян гэдэг ул мөр багатай амьдрахаас эхэлдэг тухай таниулж, өдөр бүр ажилласаар байна. Сайнаа гуай болон ‘Хүн байгаль бүлэг’-ийн гишүүдэд талархлаа илэрхийлье, эргээд хамтран ажиллахдаа таатай байх болно.





ХҮЛЭМЖИЙН ХИЙН ЯЛГАРЛАА БУУРУУЛАХ БОДИТ АЖЛУУД

“WEST-HUB” БАРУУН БҮСИЙН АГУУЛАХ НЭЭГДЛЭЭ

АПУ ХК 2023 онд Улаанбаатар хотын Баруун бүсийн агуулахын бүтээн байгуулалтын төслөө дуусгаж ашиглалтад орууллаа. Тус агуулах үүдээ нээснээр баруун бүсийн тээвэрлэлтийн хугацааг 69%, замд өнгөрүүлэх цагийг дунджаар 10 дахин хэмнэсэн нь ялгарах хүлэмжийн хийг бууруулах томоохон ажил болсон. Агуулах нь автомат агуулахын систем, цахим удирдлагын систем, санхүү, хүний нөөцийн бүх төрлийн системийн инноваци шингэсэн орчин үеийн байгууламж бөгөөд түгээлтийг илүү ойр зайд хийх боломжтой болсон тул хотын авто түгжрэлийг бууруулахад мөн өөрсдийн хувь нэмрийг оруулж чадсан гэж итгэж байна.



ЦАХИЛГААН АВТОМАШИН ТҮГЭЭЛТЭД

Дэлхий даяар бүхий л салбар бензин, дизель хөдөлгүүртэй автомашин үйлдвэрлэх, ашиглахаас татгалзаж эко буюу цахилгаан машин руу шилжин байгаль орчин, олон нийтийн эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй сонголтуудыг хийсээр байна. Үүний дагуу зах зээл, нөлөөллийн судалгаан дээр үндэслэн салбартаа анх удаа түгээлтийн үйл ажиллагаандаа цахилгаан машиныг нэвтрүүллээ. Авто замын түгжрэл хамгийн өндөр буюу Улаанбаатар хотын төвийн бүсийн түгээлтэд хоёр цахилгаан автомашин 2023 оны 6-р сарын 2-ны өдрөөс эхлэн түгээлтийн оргил ачааллын үетэй давхцан ийнхүү гарч байна. АПУ ХК 2019 оноос эхлэн дотоод хэрэгцээндээ цахилгаан машин нэвтрүүлсэн бол 2023 онд хотын түгээлтэд нэвтрүүлж буй нь энэ юм. Эдгээр машин нь хүлэмжийн хий ялгаруулдаггүй бөгөөд агаарын бохирдол, цаашлаад уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг АПУ ХК-ийн үе шаттай хэрэгжүүлж буй стратегийн нэгээхэн хэсэг болж байна. Нийслэлийн Засаг даргын 2017 оны А/613 тоот захирамжийн дагуу хотын тээвэрт оролцож буй цахилгаан машин дугаарын хязгаарлалтад хамаарахгүй учир түгээлтийг тасралтгүй бөгөөд цаг алдалгүй үргэлжлүүлэх, ингэснээр сэлгэж явуулах дизель хөдөлгүүрт машины хэрэгцээг бууруулах юм. Ирэх 5 жилийн хугацаанд түгээлтийн үйл ажиллагаандаа 30 хүртэлх тооны бүрэн цахилгаан машинаар парк шинэчлэлтээ хийхээр төлөвлөн ажиллаж байна. Ингэснээр бид байгаль орчин, эрүүл мэнд, уур амьсгалын өөрчлөлтөд үзүүлэх нөлөөллөө сайжруулах, байгууллага бүтээмж өндөртэй, ажилтнууд ая тухтай ажиллах нөхцөлийг бүрдүүлэх зорилготой юм.

“НАРНЫ ХҮҮХДҮҮД - 3” НОГООН ЦЭЦЭРЛЭГ
АПУ ХК “Нарны хүүхдүүд-3” эко ногоон шинэ цэцэрлэгийн барилгын хөрөнгө бүрдүүлэх арга хэмжээг дэмжин хамтран ажиллалаа. Энэхүү арга хэмжээ нь Вэлүү сангаас “Gobi Gallop Gala” нэртэйгээр зохион байгуулагддаг бөгөөд 10 дахь жилдээ 2023 онд болж өнгөрсөн. Вэлүү сан нь Нарны хүүхдүүд 1, 2-р цэцэрлэгийг амжилттай бүтээн байгуулж 2013 оноос хойш тасралтгүй үйл ажиллагаа явуулж өдгөө 300 гаруй хүүхдэд сургуулийн өмнөх боловсролыг олгож байна. Энэхүү шинэ цэцэрлэг баригдсанаар тус сангийн цэцэрлэгийн хүчин чадал 3 дахин нэмэгдэх бөгөөд сургуулийн өмнөх боловсролын хүртээмж сайжрах юм. Нийгэмд чиглэсэн ажлуудыг удаан хугацаанд, олон талын оролцоог амжилттай ханган хэрэгжүүлсээр байгаа Вэлүү сангийн нийт хамт олонд баяр хүргэн талархал илэрхийлье.





“ТЭРБУМ МОД” ҮНДЭСНИЙ ХӨДӨЛГӨӨН

Нийслэлийн Байгаль Орчны газартай хамтран нийслэлийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгжүүдэд байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан дүйцүүлэн хамгаалах ажлын хүрээнд Монгол улсын Ерөнхийлөгчийн 2021 оны 58 дугаар зарлиг, Засгийн газрын 2021 оны 350 дугаар тогтоол, Нийслэлийн засаг даргын 2021 оны А/908 дугаар захирамжийн дагуу **“Тэрбум мод”** үндэсний хөдөлгөөний хэрэгжилтийг хангуулж ажиллахаар нийслэлийн нутаг дэвсгэрт нэгдсэн зохион байгуулалтаар шилмүүст мод тарих ажилд АПУ ХК компани нь 500 ширхэг шинэс мод тарихаар “НҮРИ” ХХК хамтран ажиллахаар гэрээг байгуулж ажиллалаа.

ОЮУТНУУДЫН НАМРЫН МОД ТАРИЛТ

Монгол улсын нийт газар нутгийн зөвхөн 8 хувийг ой мод эзэлдэг бол 77 орчим хувь нь цөлжилтөд их бага хэмжээгээр өртөөд байгаа билээ. Мод тарьснаар дан ганц цэвэр агаар үйлдвэрлэх бус цөлжилтийн эсрэг усны ундарга, хөрсийг тэжээх, үерийн аюулаас хамгаалах зэрэг Монгол улсад тулгарч буй олон сорилтын шийдэлд бодит хувь нэмэр оруулж болдог. Бүтэн өдрийн турш багш, хамт олны хамтаар “Намрын Мод Тарилт” хийсэн ШУТИС-ын оюутнууд, зохион байгуулсан байгууллагуудад талархал илэрхийлье. Ойн сан, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх ажлыг АПУ ХК тогтмол дэмжин ажилласаар байх болно.



МАНДАЛ СУМЫН НЭГДСЭН ЭМНЭЛЭГ ХАЛУУН УСТАЙ БҮРЭН ХОЛБОГДЛОО

Мандал сумын Нэгдсэн эмнэлгийн хэрэглээний халуун усыг СББ ХХК-ийн Дулааны станцын төвлөрсөн шугамд холбож дууслаа. Уг эмнэлэг нь 1987 оноос хойш сүүлийн 35 жил хэрэглээний төвлөрсөн халуун усны шугаманд холбогдоогүйн улмаас эмнэлгийн ажилтнуудад цэвэрлэгээ хийх, эрүүл мэндийн эмчилгээ үзүүлэх, хэвтэн эмчлүүлэгчид болон үйлчлүүлэгч иргэдэд хувийн ариун цэвэр сахиад хүндрэл бэрхшээл үүсгэдэг байсан энэхүү асуудал шийдэгдсэн.

Ингэснээр 2 ширхэг уурын зуухыг буулгаж Мандал сумын агаарын чанарыг дээшлүүлэхэд хувь нэмэр оруулав.



ХҮЧИРХЭГЖСЭН ХАМТ ОЛОН

ОРОЛЦОГЧ ТАЛУУД ДАХЬ НӨЛӨӨЛӨЛ



Зорилго

Хамт олон, бусад гол оролцогч талууд маань хөгжиж дэвших боломж бүхий Монгол гэр бүлийн үнэт зүйлд нийцүүлсэн ажлын орчныг хөгжүүлснээрээ манлайлагч ажил олгогч болно.

ХҮЧИРХЭГЖСЭН ХАМТ ОЛОН



Жаргалсайханы
ИЧИНХОРЛОО
Захиргаа, Хүний нөөц
эрхэлсэн захирал

Асуулт:

АПУ ХК нь тогтвортой байдлын стратегийн хүрээнд ажилчдын сайн сайхан байдал, хөгжлийг хэрхэн чухалчилдаг вэ?

Хариулт:

Бид бүх шатны ажилтнуудад шаардлагатай сургалт, хөтөлбөрүүдийг санал болгож, тогтмол суралцах орчинг үүсгэдэг. Үүний зэрэгцээ ажил амьдралын тэнцвэрт байдлыг хангаж, хөгжиж дэвших боломжийг олгох замаар ажилчдын сайн сайхан байдал, хөгжлийг байнга чухалчилдаг. Ажлын байран дахь эрүүл мэнд, аюулгүй байдлыг нэн тэргүүнд тавьж ажилладаг тул Эрүүл мэндийг дэмжих нэгжээр дамжуулан мэргэжлийн эмч, сувилагч нар ажилтнуудад шууд хүрч ажиллаж байна. Ажилтан бүр өөр хэрэгцээ, амьдралын хэв маягтай тул бид 2023 онд BoostiBe хөтөлбөрөө эхлүүлсэн. Ингэснээр ажилтнууд эрүүл мэндийн болон гэнэтийн ослын нэмэлт даатгалуудад хамрагдаж, өөрийн хэрэгцээнд тулгуурлан ялгаатай урамшууллуудаас сонгож хэрэглэх боломжтой болоод байгаа нь ажилтнууддаа илүү сонголт, хүн бүрт тусгайлсан боломжуудыг олгох чиглэлийн томоохон эхлэл болж байна. Хувь хүний хөгжил талаас чиг үүрэг тус бүрийн зөвлөх хөтөлбөр, академиудыг хамт олон маань өөрсдөө удирдан ажиллуулж байна.

“Хүчирхэгжсэн хамт олон” хананы хүрээнд АПУ ХК нь хамт олон, бусад гол оролцогч талуудынхаа бие махбод, сэтгэлзүйн эрүүл мэндэд анхаарахын зэрэгцээ ажил мэргэжлийн хувьд хөгжиж дэвших боломжоор хангаж, ажлын уян хатан зохицуулалт болон бусад төсөл хөтөлбөрүүдээр бүрэн хангаж дэмжин ажилладаг манлайлагч ажлын байр болохыг зорьж буйг дурдахад таатай байна. Холбоотой ажлуудаа зураглан хүргэе.

Хамт олон, бусад гол оролцогч талууд маань хөгжиж дэвших боломж бүхий Монгол гэр бүлийн үнэт зүйлд нийцүүлсэн ажлын орчныг хөгжүүлснээрээ манлайлагч ажил олгогч болно.



ХАМТ ОЛОН БА СОЁЛ: БИДНИЙ АМЖИЛТЫН ТҮЛХҮҮР

АПУ ХК-ийн Хүний нөөцийн газар нь ажилчдынхаа бие махбод, сэтгэлзүйн эрүүл мэнд, санхүүгийн болон нийгмийн сайн сайхан байдлыг цогц байдлаар харж тэнцвэртэй барих, дэвжээх зорилготой билээ.

Компанийн хүрээнд хийж буй ажлуудын санааг бодит болгодог чадвартай 2799 ажилчид маань компанийн хамгийн үнэ цэнтэй

капитал юм. Хамт олон маань хийж буй ажлаараа бахархах, итгэл үнэмшилтэйгээр АПУ гэр бүлтэйгээ урт хугацаанд хамт байхын тулд ажлын орчин, уур амьсгал, шаардлагатай нөөц боломжуудыг бүрдүүлэх шаардлагатай тул АPU Life хөтөлбөрөөр дамжуулан төвлөрсөн ажлууд явж байна.



АЖИЛТАН БҮР ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧ БОЛОВ

Шунхлай групп нийт ажилтандаа АПУ ХК-ийн хувьцаа эзэмших эрхийг олгож, ажилтан бүр эзний ёсоор хандаж хамтын үнэ цэнийг хүртдэг шинэ давалгааг эхлүүлээ.

АПУ ХК-ийн ТУЗ-ийн 2023 оны 12 сарын 05-ны өдрийн тогтоолоор "АПУ ХК-ийн 1,206,810 ширхэг халаасны хувьцааг дахин гаргах замаар, ажилтнуудад хувьцаа эзэмшүүлэх хөтөлбөр"-ийг баталж, ажилласан жилийг 100 ширхэг хувьцаагаар үржүүлэн хувьцаа эзэмшүүлэхээр шийдвэрлэлээ.



ХУЧИРХУСЭН ХАМТ ОЛОН





Тодорхойлолт

Сэтгэл санааны сайн сайхан байдал нь бидний бодол, зан төлөвөө ухамсарлах мэдрэмжийн тухай юм. Энэ нь өөрчлөлт, бэрхшээлийг даван туулах, өөрийн хариу үйлдэлдээ илүү анхааралтай хандаж, эерэг сэтгэлгээг дадлагажуулж, аливаа зүйлд алсын хараатай байж, илүү тайван байдал руу хөрвөх чадвар бөгөөд танд баяр баясгалан, аз жаргалыг бэлэглэх тэр мөчүүдийг мэдрэх явдал билээ.

BOOSTIBE

БИДНИЙ ХАМТЫН АЯЛАЛ
(ШИНЭЛЭГ УРАМШУУЛЛЫН ТӨСӨЛ)

“
АПУ ХК нь нийт ажилчдынхаа ая тухтай ажиллах орчин, нөхцөлийг бүрдүүлэн, ХҮН ТӨВТЭЙ ЗАСАГЛАЛЫГ ХЭРЭГЖҮҮЛЭН ажилладаг.



Үүний хүрээнд ажилтнуудынхаа сурч хөгжих эрмэлзэл, хоорондын ялгаатай хэрэгцээ шаардлага, эрүүл амьдралын хэв маягийг бий болгох, гэр бүл, хувийн амьдралдаа анхаарал хандуулах, цаг зарцуулах зэрэг хүсэл хэрэгцээнд тулгуурлан өөрт хэрэгцээт урамшууллыг ажилтанөөрөө сонгох боломжийг олгосон BOOSTIBE урамшууллын инновацлаг хөтөлбөрийг эхлүүлсэн. Нийт 2300 гаруй ажилтнууд эрүүл мэндийн үзлэг, нэмэлт эрүүл мэндийн даатгалд хамрагдах үйлчилгээ, хүнс, шатахуун, фитнес, энтертайнмент, цахим худалдаа зэрэг түншлэгч байгууллагуудаас бүтээгдэхүүн үйлчилгээ сонгох боломжийг олгож байгаа. Хамгийн үнэ цэнтэй хүмүүн капитал болох ажилтнуудаа урамшуулж, үнэ цэнийг бий болгох нь АПУ ХК-ийн эрхэм чиглэл билээ.

Ажилтан компанитай урт удаан хугацаанд хамтын аялал хийх тусам хөнгөлөлт, урамшуулал авах үйлчилгээний эрх, үнийн дүн нэмэгддэг систем нэвтрүүлснээр **АЖИЛЛАХАД ТААТАЙ АЖЛЫН БАЙР** бүрдүүлж байна.



АПУ ХК нь ажилтнуудынхаа сонирхол, хоббиг дэмжиж, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлж, хамт олны хоорондын уялдаа холбоог сайжруулан, оролцоог нь нэмэгдүүлэх үүднээс анх 2015 онд "Сонирхлын клуб"-үүдийг байгуулсан. Энэхүү клубүүд нь "APU Hiking," "APU Photoshooting," "APU Music," "APU Cooking" зэрэг 12 спортын төрлөөр байгуулагдсан бөгөөд ажилтан бүрд өөрийн сонирхлын дагуух клубт хамрагдаж, хоббигоо хөгжүүлэх боломжийг олгож буйгаараа давуу юм.



ХҮЧИРЭХҮСЭН ХАМТ ОЛОН

"СОНИРХЛЫН КЛУБ"-ҮҮД





НИЙГМИЙН ХАРИЛЦАА

Тодорхойлолт

Нийгмийн сайн сайхан байдал нь эргэн тойрны хүмүүстэй эерэг харилцааг бий болгон, хадгалахыг хэлнэ. Найз нөхөд, гэр бүл, хамт ажилладаг хүмүүстэй эерэг харилцаатай байх нь стрессийг даван туулахад тусалдаг бөгөөд оюун санаа болон бие махбодын эрүүл мэндийг бүхэлд нь сайжруулдаг.

"APU LIFE" 2.0 ХӨТӨЛБӨР

АПУ компани нь ажиллагсад, хамт олныхоо дунд **"Эерэг амьдралын хэв маяг"** - ийг түгээцгээе уриатайгаар хөтөлбөрийг 2022 оноос эхлэн санаачлан хэрэгжүүлсээр байна. 2023 онд хөтөлбөрийн хүрээнд "People Experience" нээлттэй өдөрлөг, ажилтнууд хоорондын мэдээ мэдээлэл солилцох, харилцаа холбоог сайжруулах боломж олгох зорилгоор "Coffee Time" үйл ажиллагаануудыг компанийн бүх байршилд зохион байгууллаа. Мөн групп компанийн ажилтнуудын хоорондын нөхөрсөг харилцааг бий болгох, багаар хамтран ажиллах болон хувь хүний чадварыг сайжруулах, бие бялдрыг хөгжүүлэх, тогтмол гүйлтийг дадал болгох зорилгоор Шунхлай марафоныг үндэсний цэцэрлэгт хүрээлэнд 6-р сард зохион байгуулж аваргуудаа шалгарууллаа.

GIVING DAY:



Ажилтнууд өөр хоорондоо хэрэгцээт зүйлсээ солилцох боломжийг олгох зорилгоор "Giving day" 2023 хөтөлбөрийг зохион байгуулав. Тус хөтөлбөрөөр цугларсан ажилтнуудын эд зүйлсийг "Цэцээ гүн ротаракт" клубтэй хамтран үер усны гамшигт өртсөн найман дүүргийн 14 хорооны иргэдэд хандивлалаа.

MUSIC THERAPY:

Ажилтан бүрийн ажил, амьдралын тэнцвэрийг хадгалахад туслах, бие болон сэтгэл санааны эрүүл мэндэд анхаарах, сайн сайхан байдлын талаар бие биетэйгээ нээлттэйгээр ярилцдаг соёл, дадлыг бий болгох зорилгоор байршил бүр дээр "Aroma therapy" болон "Music therapy"-г хэрэгжүүлээд байна.

THINK FRIDAY:

Ажилтнуудын шинэ санаа, бүтээлч байдлыг нэмэгдүүлэх зорилгоор "Think Friday" үйл ажиллагааг зохион байгууллаа.



ТЭЭВЭР ТҮГЭЭЛТИЙН АЛБАНЫ ИДЭВХЖҮҮЛЭЛТИЙН ХӨТӨЛБӨР

Идэвхжүүлэлтийн хөтөлбөрийг өөрсдийн санаачилгаар АПУ ХК-ийн Тээвэр түгээлтийн алба өөрийн харъяаны 234 ажилтнуудыг хамруулан 2022 оноос хойш 3 дахь жилдээ зохион байгууллаа.

Хөтөлбөрийн зорилго:

- Түгээлтийн төлөвлөгөөг идэвхжүүлэлтийн хөтөлбөртэй уяж биелэлтийг хангах
- Хамт олны уур амьсгал, хоорондын амьд харилцаа, нэгдмэл байдлыг нэмэгдүүлэх, тогтмол байлгах
- Чөлөөт цагийг хэвшмэл биш байдлаар хамтран өнгөрүүлэх

Хөтөлбөрийн үр дүн:

Ажлын онцлогоос хамааран 4 өөр байршилд гадуур ажиллаж, хоорондоо төдийлөн холбогдох нөхцөл үүсдэггүй тус албаны залуусыг багуудад хольж хуваарилдаг. Ингэснээр зөвхөн идэвхи сайтай, харилцааны чадвар өндөртэй хүнд давуу тал, боломжуудыг үүсгэж өгөх бус өөр өөр ажлын арга барил, зан ааштай гишүүдийн авьяас чадварыг нээх, таниулах, ажлын хамт олноос АПУ гэр бүл болж хамтран өсөж хөгжих суурь нөхцөл мөн бүрдэж байгаа юм.

Тээвэр түгээлтийн албаны залуучуудын 2023 Идэвхжүүлэлтийн хөтөлбөрийн хүрээнд 3 төрлийн тэмцээн уралдаан зохион байгуулсан.

Хөл бөмбөгийн тэмцээн: 8 багийн 96 тамирчид өрсөлдөн 1, 2, 3-р байр эзэлсэн.



Тээвэр түгээлтийн албаны бэсрэг наадам дээр албаны залуусын үр хүүхэд, ар гэрийнхэн нийлсэн 490 хүн цуглаж наадамласан.



Алтан намар ургац хураалт буюу сайн үйлсийн аян өрнүүлж үүний хүрээнд албаны залуус 2023 оны 10-р сарын 1-нд Төв аймгийн Алтанбулаг суманд очин ургац хураан, ургацаас олсон орлогыг сайн үйлсийн аянд зарцуулаад байна.





Тодорхойлолт

Бие махбодын сайн сайхан байдал нь бидний бие болоод сэтгэл санааг эрүүл байлгахад тусалдаг ба үүнд эрүүл хооллолт, хангалттай унтах, дасгал хөдөлгөөн хийх багтана. Эдгээр зүйлс нь бидний биеийг хүчирхэгжүүлэн энергийг нөхөх ба аз жаргалын мэдрэмжийг нэмэгдүүлдэг.

ЭРҮҮЛ МЭНДИЙГ ДЭМЖИХ НЭГЖ:

ХҮРТЭЭМЖТЭЙ ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

Зорилго:

Ажилтнуудад эмнэлгийн яаралтай болон анхан шатны тусламжийг үзүүлэх, ажлын байрнаас хөндийрүүлэлгүй эмчлэн эрүүлжүүлэх, өвчнөөс урьдчилан сэргийлэх болон амьдралын зөв дадал хэв маяг олгохтой холбоотой нийгэм эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг зохион байгуулахад оршино.

ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭ 2023 ОНД АПУ ХК-ИЙН ХЭМЖЭЭНД:



9,348

Эмчийн үзлэг



10,822

Булчин, судас, дусал, арьсан доорх тариа



1,320

Бариа, бумба, шарлага, физик эмчилгээ



9,438

Эрүүл мэндийн зөвлөгөө, зөвлөмж



125

“Эрүүл амьдралын хэв маяг” сургалт

ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДЛУУД

- Эмнэлэгт шаардлагатай тоног төхөөрөмжийг /барианы ор, дуслын сандал, даралтын аппарат, пульсоксиметр, хүчилтөрөгчийн аппарат, дефибрилятор, зүрхний цахилгаан бичлэгийн аппарат/ судлан 2023 онд худалдан авч, Эрүүл мэндийг дэмжих нэгжийн хүртээмж, үйлчилгээний хүрээг тэлэв.
- АПУ Дэйри ХХК, М Би Си Азиа Пасифик ХХК, АПУ Трейдинг ХХК зэрэг байршлууд дээр 7 хоногийн 5 дахь өдөр бүр байрлан ажиллаж нийт 31 удаа 440 ажилтанд зөвлөгөө өгсөн.
- Шинэ ажилтны эрүүл мэндийн шаардлагатай үзлэгийн төлбөрийг төлж, Хан-Уул дүүргийн эрүүл мэндийн төвтэй хамтарч ажиллаж эхлэв. Нийт 87 ажилтны үзлэгийн төлбөрийг байгууллагаас төлөөд байна.
- “Positive Dadal” мэдээллийн сувгаар – АПУ ХК-ийн дотоод группт сэтгэцийн эрүүл мэндийн талаар болон эрүүл мэндийн зөвлөгөө мэдээллийг тогтмол хүргэн ажиллаж байна.
- Донорын өдөрлөг зохион зохион байгуулж нийт 75 ажилтан цусаа хандивлав.





АЖИЛ, МЭРГЭЖИЛ

Тодорхойлолт

Ажил мэргэжлийн сайн сайхан байдал нь хийж буй ажлынхаа зорилго, утга учрыг ойлгох, бие даан болон хамт олонтойгоо илүү үр дүнтэй хамтран ажиллахыг хэлнэ.

СУРГАЛТ ХӨГЖИЛ

АПУ ХК нь ажилчдынхаа сурч хөгжих, гадаад улсад мэргэжил дээшлүүлэх сургалтад тогтмол хамруулахаас гадна туршлага солилцох зорилгоор ажилчин солилцоогоор ажиллах боломжийг хангаж өгдөг.

Тухайлбал үйлдвэрлэл, үйл ажиллагааны газрын хүрээнд Инженер болон техникийн ажилтнуудын мэргэжлийн ур чадварыг хөгжүүлэх зорилгоор 2023 оны 04 сард Савлалтын үйлдвэр болон Тайгер үйлдвэрийн автоматик болон механикийн техникч, инженер болох 8 ажилтныг Хятад улсын Тайсан хот дах Кронесийн сургалт, лабораторийн төвд 7 өдрийн сургалт, семинарт хамрууллаа. Энэхүү сургалтаар ажилтнууд мэргэжлийн шинэ технологи, чиг хандлагатай танилцаж, лаборатори дадлагыг хийж, олон улсын үйлдвэрлэлийн чиг хандлага, дагаж мөрдөж буй стандарт зэрэгтэй танилцсан юм.

HEINEKEN ТУРШЛАГА


Бид дэлхийн топ үйлдвэрлэгч HEINEKEN компанийн бүтээгдэхүүн хөгжүүлэлт, туршлага, чанар стандартыг бүхий л түвшиндээ нэвтрүүлэн ажиллаж байна. Энэ хүрээнд дэлхийн зах зээлд томоохон тоглогч болж буй HEINEKEN компанид ажилчин солилцоогоор ажиллах боломжийг компанийн зүгээс нээлттэй олгодог.



Тухайлбал АПУ ХК-ийн Төлөвлөлтийн ажилтан Э.Намуунцэцэг Малайз улсын нийслэл Куала Лумпурт байрлалтай Хайнекен компанид Борлуулалт, үйл ажиллагаа төлөвлөлтийн чиглэлээр туршлага солилцон 6 сарын хугацаанд ажиллаж, өөрийн туршлага мэдлэгээ сайжруулан, олон улсын чанар стандарт, борлуулалт үйлдвэрлэлийн төлөвлөлттэй холбоотой төслүүд дээр амжилттай ажиллалаа.

ОЛОН УЛСЫН ТҮВШНИЙ ЧАДВАРЛАГ ХҮНИЙ НӨӨЦ

АПУ ХК нь дэлхийн топ үйлдвэрлэгч HEINEKEN компанийн бүтээгдэхүүн хөгжүүлэлт, туршлага, чанар стандартыг бүхий л түвшиндээ нэвтрүүлэн ажиллаж байна.



Нийт дотоод сургагч багш

113

Нийт сургалтын цаг

13,290

Шинэ ажилчдын сургалтын цаг

144





ОНЦЛОХ ХӨТӨЛБӨРҮҮД

АПУ ХК ажил, амьдралын тэнцвэрийг хадгалах, ажилтан бүрийн бие болон сэтгэл зүйн цогц эрүүл мэндийг дэмжих боломжийг олгох, уян хатан ажлын цаг зэрэг ажилтнууд руугаа чиглэсэн "APU Life" хөтөлбөр, сургалт хөгжлийн "APU Academy", "Менторшип хөтөлбөр", "Удирдах ажилтны цогц манлайлын хөтөлбөр", "Coaching" хөтөлбөр гэх мэт зорилтот олон төсөл, хөтөлбөр хэрэгжүүлж байна.

СОАСНING ХӨТӨЛБӨР

АПУ ХК - ийн хэмжээнд "Coaching" соёлыг бий болгох зорилгоор 28 удирдах түвшний ажилтныг СОАСН-ээр бэлтгэн 56 хүнийг сонгон хамруулсан хөтөлбөр хэрэгжүүллээ.



Ганцаарчилсан coach уулзалтад зарцуулсан цаг

84+



Ажиглалттай coaching уулзалтад зарцуулсан цаг

112



Сургалт болон холбогдох үйл ажиллагаанд зарцуулсан цаг

30+



Хөтөлбөрийг зохион байгуулахад дэмжлэг үзүүлсэн цаг

20+

Coach нарын дунд явуулсан судалгаагаар 91% нь өөрийн ур чадварыг маш сайн болон сайн гэж дүгнэсэн байна. Хөтөлбөрийн үр дүнд удирдах ажилтнуудын удирдах ур чадвар, көүч хийх ур чадвар дээшилснээс гадна зөв асуулт асуух, сонсох, асуудлын шийдэл олох ур чадварууд нэмэгдсэн. Ажилтнуудын хувьд өөртөө итгэх итгэл нэмэгдэх, өөрийгөө таньж нээх, зорилгуудаа зөв тодорхойлж түүнийгээ биелүүлэх, боломжуудыг харж чаддаг болсон.

LEADER'S MINDSET ХӨТӨЛБӨР

"Leader's Mindset" хөтөлбөрт чиг үүрэг тус бүрийн дотоод ажилтнуудаас сонгосон ба сургагч багш нарыг бэлтгэхдээ ORP Institute of Korea /Korean and Mongolian Consultants/ институтийн Манлайлын сургалтыг дүүргэж, цааш удирдлагуудад заах арга барил эзэмших сургалт болон бэлтгэл ажилд нийт 242 цагийг зарцууллаа. 2023 оны 05-р сараас 09-р сарыг дуустал хугацаанд 8 ангийг 16 удаагийн давтамжтай 128 цагийн сургалтыг 140 удирдлага, менежер, ахлах ажилтнуудыг хамрууллаа.



5 ЦАГААС 11 МИНУТ ЛУУ:

АЖИЛТНЫ ЦАГ БОЛ АЛТ



А ж и л т н у у д ы н х а бүтээмжийг нэмэгдүүлэх чиглэлийн хүрээнд шинэ ажилтнууддаа компанийн Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, мэдээллийн аюулгүй байдал, эрүүл мэндийн

зааварчилгааг цахимаар авах боломжийг АПУ ХК 2023 онд бүрдүүллээ.

Байгууллагын дата дээр суурилсан энэхүү шинэчлэлтээр нэг шинэ ажилтанд зааварчилгаа өгөхөд хоёр талаас тус бүр зарцуулдаг байсан 5 цаг, 10183 алхам, жилийн хугацаанд хэрэглэдэг 1400 гаруй цаасыг дунджаар хэмнэлээ. Энэ үйл явцыг цахимаар шийддэг болсноор ажлын 11 минутыг зарцуулан цаас, нэмэлт цаг ашиглалгүйгээр шаардлагатай бүх мэдээллийг байгаа газартаа авах боломжийг бий болгосон. Энэ нь байгууллагатай дөнгөж танилцаж буй ажилтнууд болон холбоотой заавар өгдөг байсан ажилтнуудын өдөр тутмын цагийг илүү үр дүнтэй ашиглах, ойлгомжгүй үйл явцыг халах, цаас хэмнэх ажил болсон юм.



ОЛОН НИЙТЭД ЧИГЛЭСЭН АРГА ХЭМЖЭЭНҮҮД

APU COMPANY
Absolute. Pure. Unique.

CRAFT
YOUR

ДЭЛХИЙН БРЭНДИЙГ ХАМТДАА БҮТЭЭ

АНУ

- CHINGGIS KHAN
- SOYOMBO

КАЗАКСТАН

- CHINGGIS KHAN
- CHINGGIS GRAND KHAAN

ОХУ

- CHINGGIS KHAN
- SOYOMBO
- EVOK
- EDEN
- ARKHI, ARKHI EXPORT
- CHINGGIS GRAND KHAAN

- ALTAN TURUU
- AGAR
- BORGIO
- ALTAN GOBI
- SENGUR

БНХАУ

- CHINGGIS KHAN
- SOYOMBO
- EDEN
- CHINGGIS GRAND KHAAN
- SENGUR

БНСУ

- EDEN
- ALTAN GOBI

ПОЛЬШ

- CHINGGIS KHAN
- SOYOMBO
- EVOK
- EDEN

АПУ ХК "ХҮРТЭЭМЖТЭЙ ХӨДӨЛМӨРИЙН ӨДӨРЛӨГ 2023"

НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөрийн "Монгол улсад тогтвортой хөгжлийн зорилготой уялдсан төлөвлөлтөөр хөдөлмөр эрхлэлтийн шинэчлэлийг дэмжих нь" төслийн хүрээнд 10-р сарын 25-ны өдөр идэвхтэй ажил хайж буй хөгжлийн бэрхшээлтэй иргэд хүрэлцэн ирж АПУ ХК-ийн нээлттэй ажлын байруудтай танилцан, сонирхсон иргэд ажлын байранд бүртгүүллээ.

ХУЧИРХУХСЭН ХАМТ ОЛОН



"КАРЬЕРАА УРЛА" НЭЭЛТТЭЙ ӨДӨРЛӨГ

АПУ ХК нь олон нийтэд чиглэсэн "CRAFT YOUR CAREER - Карьераа урла" ажлын байрны нээлттэй өдөрлөгийг цуврал байдлаар 2023 онд зохион байгууллаа. Өдөрлөгийн үеэр АПУ ХК-ийн бүтэц, хүн төвтэй засаглал, тогтвортой хөгжлийн үйл ажиллагааг танилцуулан, автобус үйлчилгээ, урлагийн тоглолт, АПУ үйлдвэрийн аялал, хөгжөөнт тэмцээн гэх мэт олон үйл ажиллагаагаар бид ирээдүйн ажилтнуудтайгаа холбогдсон.

Мөн Хөдөлмөр, Нийгмийн Хамгааллын Яам, Гадаадад Төгсөгчдийн Холбоо, HR CLUB хамтран зохион байгуулсан CAREER EXPO-2023 залуучуудын хөдөлмөрийн өдөрлөгийг АПУ ХК дэмжин ажилласан. Энэхүү үйл ажиллагаа нь эх орондоо болон гадаадад сурч, ажиллаж буй залуучуудын хөгжил, хамгаалал, хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, хөдөлмөрийн харилцааны хүрээн дэх хууль тогтоомж, бодлого, үйл ажиллагааг сурталчлан таниулах байнгын болон цагийн ажилд зуучлах зорилготой байсан. Уг арга хэмжээнд АПУ ХК-ийн зүгээс цахим шилжилтийн хүрээнд нээлттэй сонгон шалгаруулалтын <https://hello.aru.mn/> цахим системээ танилцуулж, нээлттэй зарлаж буй ажлын байрандаа хүний нөөцийн бүрдүүлэлт хийсэн юм. Уг сайтаар нэвтэрснээр АПУ групп компанид анкет хүлээн авч байгаа нийт нээлттэй зарыг нэг дороос харж материалаа өгөх боломжтой. Ингэснээр нээлттэй сонгон шалгаруулалтыг хүртээмжтэй, түргэн шуурхай, байршлын хязгаарлалтгүйгээр хийх боломж бүрдээд байна.



АПУ компанид одоогоор 37 хөгжлийн бэрхшээлтэй ажилчидтай ба бид хүртээмжтэй ажлын байр бий болгох чиглэлээр иргэдийг дадлагажуулах, сонгон шалгаруулалтаа идэвхжүүлэх зэргээр хүчин чармайлт гарган ажиллаж байна.

ХАМТРАН БҮТЭЭХ ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ

59

БАЯЛАГ, ХАРИУЦЛАГАТАЙ
ХЭРЭГЛЭЭ
ХАРИУЦЛАГАТАЙ

Зорилго

Өдөр тутмын амьдрал болон хэрэглээнд эрүүл сонголтуудыг сэдэлжүүлж, боломжийг нэмснээр Монгол мөн чанар шингэсэн зохистой амьдралын хэв маягийг дэвжээнэ.



YESPI

БАЯЛАГ БА ХАРИУЦЛАГАТАЙ



Батсайханы
ЦАЦРАЛ
Борлуулалт, маркетинг
эрхэлсэн захирал

Асуулт:

АПУ хэрхэн бүтээгдэхүүнээрээ дамжуулан хариуцлагатай хэрэглээг дэмжиж, эрүүл амьдралын хэв маягт хувь нэмэр оруулдаг вэ?

Хариулт:

Соёлтой хэрэглээг таниулах мэдлэг мэдээллийг агуулсан дижитал шошго бүхий бүтээгдэхүүнүүдээр дамжуулан хэрэглэгчдэд зөв мэдээлэл түгээхийг зорьж байна. Мөн хог хаягдлыг бууруулах “Байгальд биш, байх ёстой газар нь”, “Гайхамшигт жолооч” зэрэг эерэг нөлөөллийн аянуудыг хэрэгжүүлсээр байгаа. Бүтээгдэхүүн хөгжүүлэлтийн хувьд дэлхийн трендийг хурдтай нэвтрүүлж, чихрийн агууламжгүй, тослог багатай бүтээгдэхүүнүүд зах зээлд нэвтрүүлэхийн зэрэгцээ шинэ соёл, шинэ хэрэглээг бий болгосон RTD (Ready to drink) коктейлийг Монголд анх удаа үйлдвэрлэж, хэрэглэгчдэд хүргэлээ.

“Баялаг ба Хариуцлагатай” хананы хүрээнд бид хэрэглэгчдийнхээ зохистой хэрэглээг дадал болгох, эерэг, хариуцлагатай хандлагыг түгээж, уриалахыг зорихоос гадна эрүүл сонголтуудыг сэдэлжүүлж, боломжийг нэмэх төсөл хөтөлбөрүүдэд ач холбогдол өгөн ажиллаж байна.

Өдөр тутмын амьдрал болон хэрэглээнд эрүүл сонголтуудыг сэдэлжүүлж, боломжийг нэмснээр Монгол мөн чанар шингэсэн зохистой амьдралын хэв маягийг дэвжээнэ.



ХҮРТЭЭМЖТЭЙ, ХАРИУЦЛАГАТАЙ МЭДЭЭЛЛИЙГ ДИЖИТАЛ ШОШГООР

Хариуцлагатай хэрэглээний талаар мэдлэг, ойлголтыг дижитал шошгоор дамжуулан хэрэглэгчдэд хүртээмжтэйгээр хүргэх зорилтын дагуу хариуцлагатай хэрэглээг сурталчилсан Монголын анхны дижитал шошгыг бүтээгдэхүүнүүддээ нэвтрүүллээ.

Бид бүтээгдэхүүндээ инновацыг тасралтгүй нэвтрүүлж, шинэлэг шийдлүүдийг шингээн ажиллахыг эрмэлздэг. Дэлхий даяар зохистой хэрэглээг хэрэглэгчдэдээ сурталчлан таниулж, мэдлэгжүүлэх олон төрлийн аян өрнөж буй энэ үетэй АПУ ХК хөл нийлүүлэн алхаж бүтээгдэхүүнүүддээ зохистой, хариуцлагатай хэрэглээг таниулах, дижитал, хүртээмжтэй шийдлийг нэвтрүүлж буй нь энэ юм.

Дэлхийн шингэн хүнсний томоохон брэндүүдийн жишгийн дагуу АПУ ХК нэг алхам урагшилж, соёлтой, хариуцлагатай хэрэглэгчийн зан төлөвийг таниулж, уриалан ажиллаж байна.



"ГАЙХАМШИГТ ЖОЛООЧ – УУСАН БОЛ ЖОЛОО БАРЬДАГГҮЙ" НӨЛӨӨЛЛИЙН АЯН



АПУ ХК "Соёлоор гоёно" хөтөлбөрийн дэд хэсэг болох "Гайхамшигт жолооч – Уусан бол жолоо барьдаггүй" нөлөөллийн аяныг 2023 онд хэрэгжүүлж, 11,000 хүний амлалтыг аваад байна. Энэхүү нийгэмд чиглэсэн нөлөөллийн аян маань "Мөнгөн Мод 2023" наадамд "Шилдэг зар сурталчилгааны бүтээл" шагналыг хүртлээ.



МӨНГӨНМОД 2023

Компанийн тогтвортой хөгжлийн стратегийн нэг хэсэг болох "Хариуцлагатай хэрэглээ"-г сэдэлжүүлэх гол зорилгоор замын хөдөлгөөний аюулгүй байдал, согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодохын эсрэг хэрэгжүүлж буй ажил бөгөөд бид Тээврийн Цагдаагийн алба, "UB Cab" байгууллагуудтай хамтран ажиллаж, жолоодлогын үйлчилгээний талаарх мэдлэг, мэдээллийн хүртээмжийг нэмэгдүүлсэн нь энэ билээ. Энэ хүрээнд "UB Cab"-аас зохион байгуулсан 1000 жолоочийн чуулга уулзалтад энэхүү нийгмийн эерэг нөлөөллийн аянаа танилцуулан оролцож, жолооч нарын амлалтыг авах байдлаар зан төлөвт нь нөлөөлөх, амлалт өгсөн бол хэрэгжүүлэх сэдэл идэвхтэй төрдөг талаарх судалгаан дээр үндэслэн олон нийтэд уриалан ажиллаж байна. Жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг "ОктоберФест" болон "Их Хотын Баяр" арга хэмжээнүүдээр дамжуулан АПУ ХК тус аяныг танилцуулж, хүрэлцэн ирсэн нийт 6,400 залууст хүрч, мэдээллийг түгээжээ.



ЗОХИСТОЙ ХЭРЭГЛЭЭГ БОДИТ СОНГОЛТООР ДЭМЖИХ НЬ

АПУ ХК 2023 онд “Нийслэл” шар айргийн “LITE” нэртэй хатуулаг багатай хувилбарыг шинээр зах зээлд танилцуулсан. Энэ нь АПУ ХК-ийн бүтээгдэхүүн хөгжүүлэх үйл явц залуусын дунд зохистой, хариуцлагатай хэрэглээг дэмжиж, үүний дагуу хатуулгын сонголтыг шинэ бүтээгдэхүүнүүдээр дамжуулан өгч байгаа хэрэг юм.

Бид тогтвортой хөгжлийн стратегийн хүрээнд хэрэглэгчдэдээ 0.0 хатуулагтай шар айргийг үйлдвэрлэж хүргэхээр мөн үе шаттайгаар зорин ажилласаар байна. Бид бүх бүтээгдэхүүнийхээ мэдээллийг 100% тодорхой, ил тод байлгахыг зорьж, шим тэжээл орц найрлагын бүрэн мэдээлэл, дижитал шошго, сав баглаа боодлын дахин боловсруулах тэмдгийг багтаадаг.


**KEEP IT
LITE**

Нийслэл

4.9%

4.3%

**MORE FRESH
LITE TASTE**



ХАРИЛЦАГЧДЫН ЗОХИСТОЙ МЭДЛЭГ

“COMFORT CONNECT” харилцагчийн арга хэмжээг зохион байгуулж, Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архиан согтуурахтай тэмцэх тухай шинэчилсэн хуулийн танилцуулгын мэдээллийг хүргэж, харилцагч байгууллагын хамтын ажиллагааг сайжруулах шинэ бүтээгдэхүүнийг танилцуулах уулзалтыг зохион байгуулсан. АПУ ХК-ийн хэрэглэгчидтэй өдөр тутам шуудаар харьцаж буйн хувьд харилцагчид маань зохистой хэрэглээний ойлголттой байх, таньж мэдэх чадвартай байх нь чухал юм. Нийт 250 гаруй харилцагчийг мөн архи, шар айраг, ус ундааны үйлдвэрүүдтэй танилцуулж үйлдвэрлэлийн үйл явцаа танилцуулсан. Энэхүү үйлдвэрийн аяллын гол ач холбогдол нь зохистой хэрэглээг дэмжсэн мэдлэгийг түгээх, борлуулж буй бүтээгдэхүүний үүх түүхийг олж мэдэх, хамтын тогтвортой харилцааг бий болгох, дотооддоо бүтээгдэхүүн үйлдвэрлэж буй давуу талуудыг ойлгуулах байв.





**СПОРТЫГ ДЭМЖИХ ХАМТЫН АЖИЛЛАГАА
FC ULAANBAATAR**

АПУ ХК нь хөл бөмбөгийн спортын хөгжлийг дэмжих замаар залуучуудын эрүүл амьдралын хэв маяг, зөв дадал хэвшлийг бий болгох зорилгоор “ФС УЛААНБААТАР” хөл бөмбөгийн шигшээ багийг сүүлийн 10 орчим жилийн хугацаанд дэмжин, хамтран ажиллаж байна. 2023 оны хагас жилийн хувьд “Улаанбаатар” Клуб 12 жилийн дараа дээд лигийн аварга болж МХБХ-ны нэг тэрбумын шагналын сантай 2022-2023 оны улирлын “Моби Дээд Лиг” 2022 оны 8-р сарын 23-ны өдрөөс өнөөдрийг хүртэл анх удаагаа 27 тойргийн тоглолтууд хийгдсэнээс 59 оноотой тэргүүлж, аваргын болзол хангаж, дээд лигийн аваргаар шалгарлаа. 2023 оны хөл бөмбөгийн дээд лигийн аварга болсноор улсаа төлөөлөн олон улсын тэмцээн болох Азийн Клубүүдын аварга шалгаруулах тэмцээнд 6 тоглолтоос 4-т нь хожиж, Монголын хөл бөмбөгийн түүхэн дэх дээд амжилтыг тогтоосон билээ.

**ШАЙБТАЙ ХОККЕЙН
ДЭЛХИЙН АВАРГА
ШАЛГАРУУЛАХ ТЭМЦЭЭН**


АПУ ХК нь Шайбтай хоккейн дэлхийн аварга шалгаруулах тэмцээнийг дэмжин ажиллалаа. Монгол улсад анх удаа зохион байгуулагдсан Шайбтай хоккейн Ази болон Дэлхийн аварга шалгаруулах тэмцээнийг дотоод брэндүүдээрээ дэмжин ажиллаж залуусын соёлтой, хариуцлагатай хэрэглээг бий болгох чиглэлээр хүчин чармайлт гарган ажиллалаа.



ҮНДЭСНИЙ ДЭЭД ЛИГ

АПУ ХК нь залуучуудын эрүүл амьдралын хэв маягийг дэмжих, зөв зохистой, хариуцлагатай хэрэглээг сурталчлах зорилгоор сагсан бөмбөгийн спортын хөгжилд хувь нэмэр оруулан “Монголын Сагсан Бөмбөгийн Холбоо” /МСБХ/-той 2 дэх жилдээ хамтран Үндэсний Дээд Лиг 2023-2024 оны улирлыг амжилттай зохион байгууллаа. Мөн АПУ ХК-ийн Сэнгүр брэнд нь 2013 оноос Үндэсний Сагсан Бөмбөгийн Холбооноос зохион байгуулдаг Монголын хамгийн том, чансаа өндөртэй Супер Лиг болон Үндэсний 21 аймгийн лигийн ерөнхий ивээн тэтгэгчээр тасралтгүй 10 жил ажиллаж, спортод хайртай залуусын сонирхол, хүсэл тэмүүллийг ийнхүү дэмжсээр байна. Энэ удаагийн сагсан бөмбөгийн спортын хамтын ажиллагааны нээлтийн үеэр АПУ ХК-ийн Гүйцэтгэх захирал Ц.Эрдэнэбилэг: “Сагсан бөмбөгийн спорт нь багийн спорт гэдгээрээ онцлог бөгөөд хамтын амжилт, хамтын соёлыг бий болгож, эв нэгдэлтэй, ээлтэй нийгмийг цогцлооход үнэтэй хувь нэмэр оруулж байна. Мөн Монголд төдийгүй дэлхий даяар хүн амын эрүүл мэнд, залуусын чөлөөт цагаа өнгөрүүлэх зөв дадал хэвшилд эергээр нөлөөлж байна. Тиймээс бидний цаашдын тогтвортой хамтын ажиллагаа эрүүл Монгол хүнийг бий болгоход хувь нэмэр оруулна гэж итгэж байна” хэмээн онцоллоо.





ИЛ ТОД БАЙДАЛ, ЗАСАГЛАЛ
ТОГТВОРТОЙ ТҮНШ

Зорилго

Монголын нээлттэй хувьцаат компаниудын дунд байгаль орчин, нийгэм, засаглалын нөлөөллөөрөө жишиг байгууллага байна.

ТОГТВОРТОЙ ТҮНШ



Чадраабал
АРИУНСАН
ТУЗ-ийн Нарийн бичгийн
дарга

Асуулт:

АПУ ХК үйл ажиллагааныхаа ил тод байдал, засаглалыг сайжруулахын тулд ямар арга хэмжээ авч байна вэ?

Хариулт:

Бид засаглалыг сайжруулах үйл ажиллагаандаа 2022 онд СЗХ-оос шинэчлэн батлагдсан Компанийн засаглалын кодексийн зарчим ба тайлбаруудыг мөрдлөг болгохыг эн түрүүний зорилго болгон ажилласан. Үүний дагуу ТУЗ-өөс баталдаг засаглалын баримт бичгүүдийг бүхэлд нь шинэчилсэн ба цаашид комплайнс болон дотоод аудитын тогтолцоогоо бэхжүүлэх, Байгаль Орчин, Нийгэм, Засаглал (БОНЗ)-ын олон улсын стандартуудыг тайлагналдаа нэвтрүүлэн хэвшүүлэх асуудлыг анхаарлын төвдөө тавиад байна. Энэ бүх зорилтуудыг аль болох богино хугацаанд, үр дүнтэйгээр биелүүлэхийн тулд дижитал шилжилт зайлшгүй шаардлагатай бөгөөд энэ чиглэлээр ойрын хугацаанд дорвитой ажлууд хийгдэнэ гэсэн хүлээлт, төлөвлөлттэй ажиллаж байна.

АПУ ХК нь дотоодын хүнсний салбрын нийтлэг асуудлуудыг хамтран шийдэхэд чиглэсэн түншлэл, салбарын форум, санаачилгуудаар дамжуулан дуу хоолойгоо хүргэсээр байгаа. "Тогтвортой түнш" хананы хүрээнд 2023 онд АПУ ХК хамтын ажиллагаанд тулгуурласан ажлуудаа онцлон хүргэж байна.

Монголын нээлттэй хувьцаат компаниудын дунд байгаль орчин, нийгэм, засаглалын нөлөөллөөрөө жишиг байгууллага байна.



НҮБ БОЛОН ХУВИЙН ХЭВШЛИЙН ХАМТЫН АЖИЛЛАГАА

Зуу дахь жилийн босгоо давж буй АПУ ХК-д байгууллага доторх засаглалаа дээд түвшинд барихтай зэрэгцэн бүх хамтран ажиллаж буй хамтрагч, харилцагч, хэрэглэгч нартаа ТОГТВОРТОЙ, жишиг ТҮНШ байх нь эн тэнцүү чухал.

Энэ ч утгаараа 2023 онд бид НҮБ-ын Тогтвортой хөгжлийн чуулганыг дэмжин ажиллаж, "ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛД ХӨТЛӨГДСӨН БИЗНЕСИЙГ ХАМТРАН БҮТЭЭХ НЬ" сэдвийн дагуу салбарын тогтвортой хөгжлийг хамтран бүтээх зорилгын хүрээнд бодитоор хэрэгжүүлсэн сайн туршлагуудаа хуваалцаж, үйлдлээрээ нэгдэхийг бүх оролцогч талд уриалсан. Бид өөрийн ханган нийлүүлэх сүлжээнд нэмүү өртгийг жигд тарааж, сүү бэлтгэн нийлүүлэгчид, тариаланчдын орлогыг өсгөх, цаашлаад орон нутгийн хөгжлийг хурдасгах, хот руу чиглэсэн шилжилт хөдөлгөөнийг сааруулах, импортыг орлох, экспортын боломжийг нээх зэрэг тогтолцооны өөрчлөлтүүдийг хийсээр байгааг бизнесийн салбарын сайн жишиг болгон үргэлжлүүлэн ажиллах юм.





НҮБ-ын Суурин зохицуулагч Талан Мишра болон багийн гишүүдтэй АПУ ХК-ийн удирдлагын баг мөн уулзаж орон нутагт нэмүү өртөг шингээсэн үйлдвэрлэлийг үе шаттайгаар байгуулж буй талаар мэдээлэл өгч ярилцсан.

Малчдын хөдөлмөрийг хөнгөвчлөх, амьдралын чанарыг сайжруулах, тогтмол орлогын эх үүсвэрийг бий болгох тогтвортой хөгжлийн томоохон ач холбогдолтой ажлуудаа бид баяртайгаар хуваалцсан. Цаашид сүүний салбарыг сүү бэлтгэн нийлүүлэгчид, хувийн хэвшил, төр, олон улсын байгууллагууд болон бусад оролцогч талууд хамтран хөгжүүлэх олон боломж, хамтын ажиллагааг нэмж хэлэлцсэн. Эдгээр ажлууд хүнсний аюулгүй, тогтвортой байдлыг хангах, орон нутгийн хөгжилд хувь нэмэр оруулах бөгөөд НҮБ-ын Суурин Зохицуулагч бүрэн дэмжиж ажиллахаа мэдэгдсэнд бид маш их баяртай байна.

ТОС ХОЛБООНЫ БОНЗ-ЫН МЭРГЭЖЛИЙН ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮН

Тогтвортой Санхүүгийн (ТоС) Холбоо нь гишүүн байгууллагуудын тогтвортой хөгжлийн стратеги, засаглал, дотоод үйл ажиллагаа, болон тайлагналыг хөгжүүлж, бэхжүүлэхэд чиглэж ажиллах "Тогтвортой байдал, байгаль орчин, нийгэм, засаглал (БОНЗ)-ын удирдлага хариуцсан мэргэжлийн зөвлөл"-ийг шинээр үүсгэн байгуулсан. Энэхүү зөвлөлийн анхны гишүүдийн нэгээр АПУ ХК санхүүгийн бус бизнесийн салбарыг төлөөлөн нэгдсэн нь 2023 оны онцлох үйл явдал, чухал хамтын ажиллагааны эхлэл байлаа. Үйлдвэрлэлийн, тэр дундаа шингэн хүнсний салбар дундын сорилт, шийдлүүдэд БОНЗ-ын зарчмуудыг баримтлан эерэг нөлөөлөл үзүүлэх, нэг байгууллага бус салбараараа хамтран хөгжих, хөдлөх талаар ТоС Холбооны хамт олонтой ээлж дараалан хуваалцаж, боломжит байдлаар хамтран ажиллалаа.



Жилийн эхэнд АПУ ХК анх удаа Тогтвортой хөгжлийн тайлангаа тусгайлан гаргасан бөгөөд Монголын хөрөнгийн бирж, Санхүүгийн зохицуулах хороо зэрэг томоохон байгууллагууд хамтран гаргасан удирдамжийн дагуу 2022 оны БОНЗ-ын тайлагналаа мөн сайн дураар гүйцэтгэсэн. Холбооноос 11-р сард зохион байгуулсан Сингапурын шилдэг БОНЗ-ын туршлагаудтай танилцах аялалд АПУ ХК-ийн төлөөлөл оролцсон нь ТУЗ болон хамт олныг олон улсын мэдээлэл, цаг үеийн тогтвортой хөгжлийн мэдээллээр хангах томоохон боломж болж өгсөн. Бид үргэлжлүүлэн тогтмол хамтран ажиллаж, тогтвортой хөдөө аж ахуйд олон талын оролцоог хангаж, үр дүн өндөртэй ажлуудыг хамтран гүйцэтгэнэ гэдэгт итгэлтэй байна. Өрсөлдөх бус хамтран бүтээх зарчмыг бодит ажил болгож, манлайлж яваа ТоС Холбооны хамт олонд талархлаа илэрхийлье.

Компанийн засаглалын бодлогуудыг шинэчиллээ

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2023 оны 01 дүгээр сарын 24-ны өдрийн хурлаар Компанийн засаглалын дараах 15 бодлого, журмуудыг Компанийн засаглалын кодекст нийцүүлэн шинэчлэн болон шинээр баталсан.

1. Ногдол ашгийн бодлого;
2. Цалин урамшууллын бодлого;
3. Залгамж халааны бодлого;
4. Дотоод аудитын бодлого;
5. Эрсдэлийн удирдлагын бодлого;
6. Дотоод хяналтын бодлого;
7. Оролцогч талуудтай харилцах, хамтран ажиллах бодлого.
8. Хувьцаа эзэмшигчдийн хурлыг зарлан хуралдуулах журам;
9. Мэдээллийн ил тод байдал, тайлагналын журам;
10. ТУЗ-ийн үйл ажиллагааны журам;
11. ТУЗ-ийн дэргэдэх Нэр дэвшүүлэх хорооны журам;
12. ТУЗ-ийн дэргэдэх Цалин урамшууллын хорооны журам;
13. ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хорооны журам;
14. ТУЗ-ийн Нарийн бичгийн даргын үйл ажиллагааны журам;
15. Гүйцэтгэх захирлын үйл ажиллагааны журам.

Бизнесийн ёс зүйн дүрмийг шинээр баталлаа.

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2023 оны 02 дугаар сарын 13-ны өдрийн хурлаар Бизнесийн ёс дүрмийн багц бодлогын баримт бичиг болох 15 бодлого дүрмийг баталсан.

1. Хүний эрхийн бодлого;
2. Өрсөлдөөний бодлого;
3. Авлигын эсрэг бодлого;
4. Бэлэг хандивын бодлого;
5. Мөнгө угаах, хориг арга хэмжээний бодлого;
6. Ашиг сонирхлын зөрчлийн бодлого;
7. Компанийн хөрөнгө ашиглах бодлого;
8. Залилангийн эсрэг бодлого;
9. Нууц мэдээллийн бодлого;
10. Оюуны өмчийн бодлого;
11. Олон нийтийн сүлжээ ашиглах бодлого;
12. Согтууруулах ундааны хариуцлагатай хэрэглээний бодлого;
13. Нийлүүлэгчийн дүрэм;
14. Сахилгын арга хэмжээний бодлого;
15. Шүгэл үлээх бодлого.

Комплайнсын хяналтын зааврыг шинээр баталлаа.

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2023 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн хурлаар “Комплайнсын хяналтын заавар”-ыг шинээр баталсан.

Комплайнсын хяналтын хөтөлбөрийг хэрэгжүүлж ажиллаж эхэлж байна.

Батлуулахаар хүлээгдэж байгаа журмууд:

1. Тогтвортой хөгжлийн стратегийг;
2. Сонирхлын зөрчилтэй хэлцлийг байгуулах бодлого, журам.

2023 онд Тогтвортой хөгжлийн стратеги, бодлогыг тодорхойлох ажлыг гуравдагч мэргэжлийн байгууллагатай хамтран хийж, эхний үр дүнг Төлөөлөн удирдах зөвлөлд танилцуулан, сайжруулан боловсруулах ажил хийгдэж байна. Сонирхлын зөрчилтэй хэлцлийг байгуулах журмыг боловсруулж байна.

Компанийн Засаглалын Кодексын хэрэгжилтийн үнэлгээ:

АПУ ХК-ийн Компанийн Засаглалын Кодексийн хэрэгжилтийг Санхүүгийн зохицуулах хорооноос хянан баталгаажсан үнэлгээгээр 2023 оны эцэст 93%-ийн үнэлгээгээр "ЗАСАГЛАЛ ХЭВИЙН, ЭРСДЭЛГҮЙ" 4-р байранд эрэмбэлэгдлээ.

АПУ ХК-ийн "КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН КОДЕКС"-ИЙН НЭГДСЭН ҮНЭЛГЭЭ

№	Гарчиг	Авбал зохих нийт оноо	2023 оны I хагас жил		2023 оны эцэс	
			Үнэлсэн оноо	Үнэлгээний хувь	Үнэлсэн оноо	Үнэлгээний хувь
1	ТУЗ-ийн бүтэц, зохион байгуулалт	12	11	92%	10	83%
2	ТУЗ-ийн дэргэдэх хороод, тэдгээрийн чиг үүрэг	10	10	100%	10	100%
3	Тайлагнал, мэдээллийн ил тод, байдал	6	6	100%	6	100%
4	Аудит, хяналтын тогтолцоо	6	4	67%	6	100%
5	Эрсдэлийн удирдлага	8	7	88%	7	88%
6	Эрх бүхий албан тушаалтны цалин урамшуулал	6	6	100%	6	100%
7	Оролцогч талуудын эрх ашиг	8	8	100%	8	100%
8	Компанийн соёл	6	5	83%	5	83%
9	Хувьцаа эзэмшигчдийн эрх	10	8	80%	9	90%
Нэгдсэн дүн		72	65	90%	67	93%
			Засаглал хэвийн буюу эрсдэлгүй		Засаглал хэвийн буюу эрсдэлгүй	

ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА

Эрсдэлийн удирдлагын бодлого

Эрсдэлийн удирдлагын бодлогыг ТУЗ-ийн 2023 оны 01-р сарын 24-ний өдрийн хурлаар шинэчлэн баталсан. Тус бодлогоор эрсдэл гэдэгт компани зорилго, зорилтдоо хүрэхэд учрах тодорхой бус байдал, үр дагавар, гарз хохирлыг ойлгоно.

Компанийн эрсдэлийн удирдлагын үйл явц нь эрсдэлийг тодорхойлж бүртгэх, эрсдэлийг үнэлэх, эрсдэлийг удирдах гэсэн үндсэн гурван үе шатыг хамарна. Эрсдэлийг эх үүсвэрээс нь хамааруулан гадаад, дотоод эрсдэл, үр

Эрсдэлийн мэдээлэл

АПУ ХК нь байгаль орчин, нийгэм, эдийн засагт ээлтэй засаглалыг бэхжүүлэхэд чиглэн ажиллаж байна. Үүний тулд бид эрсдэлийн удирдлагын шинэ чиг хандлага болох тогтвортой хөгжилд чиглэсэн эрсдэлийн удирдлагын соёлыг түгээн дэлгэрүүлэхэд ихээхэн анхаарч, аливаа болзошгүй эрсдэл, тодорхойгүй нөхцөл байдлыг урт хугацаандаа оновчтой удирдах, шинэ боломжуудыг эрэлхийлэн ажилласаар ирлээ.

Ирэх жилүүдэд дэлхий дахинд төдийгүй манай салбарын үйл ажиллагаанд шууд болон дам байдлаар нөлөөлөх дараах таван чиглэлийн эрсдэлийг бид онцолж байна. Үүнд байгаль цаг уурын өөрчлөлт, хүлэмжийн хийн асуудлууд, геополитикийн зөрчилдөөн, үүнээс үүдсэн эдийн засгийн тодорхойгүй байдал, шинэчилсэн хуулийн шаардлагууд, болон мэдээллийн оновчтой бус урсгалын нөлөөллүүд багтана.

Нэг нь нөгөөгөөсөө харилцан уялдаа холбоотойгоор орших эдгээр эрсдэлүүд нь бидний бизнесийн үйл ажиллагаанд цогцоороо томоохон сорилтуудыг дагуулж байна. Ялангуяа байгаль цаг уурын өөрчлөлт нь зарим бүс нутагт их хэмжээний хур тунадас, үерийн аюул дагуулж байгаа бол өөр нэг хэсэгт ган зуд болох эрсдэлийг учруулснаар хөрсний гулгалт, элэгдэл үүсэх, гал түймэр гарах зэргээр экосистемийн олон талт байдалд дам байдлаар, компанийн өдөр тутмын үйл ажиллагаанд шууд байдлаар нөлөөлсөн үйл явдлууд өнгөрсөн онд ихээхэн тохиолдсон.

Харин урт хугацаандаа хүний үйл ажиллагаанаас үүдэлтэй эрсдэлүүд, түүн дотроо хүлэмжийн

дагавраас хамааруулан стратегийн, санхүүгийн, үйл ажиллагааны, комплайнсын, бусад эрсдэл хэмээн ангилдаг.

Эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална:


- Соёлыг түгээх,
- Үнэ цэнийг бүтээх,
- Шийдвэр гаргалтад ашиглагдах,
- Мэдээлэлтэй, ил тод байх,
- Тасралтгүй байх.

хийн ялгарал нэмэгдэх эрсдэл нь бидний хүрээлэн буй орчинд илүү ноцтой нөлөөллийг авчрах магадлалтай тул эдгээр асуудлын суурь шалтгаануудад АПУ ХК онцгой анхаарал хандуулж тогтвортой хөгжлийн зорилго, зорилтууддаа тусган, зохистой хариу арга хэмжээг төлөвлөж, шаардлагатай төсөл хөтөлбөрүүдийг санаачлан эхлүүлээд байна.

Тухайлбал: CO2 бууруулах уурын зуухны төсөл, Саарал усны хаягдлыг дахин ашиглах төсөл, Монгол бяслаг, Шигүдэри урлах үйлдвэрийн хүлэмжийн хийг бууруулах шийдлүүд, Хог хаягдлын 3R стратегийг хэрэгжүүлэх арга хэмжээнүүдийг дурдаж болно. Мөн бид санхүү, зардлын ухаалаг хэмнэлтийг сахин биелүүлж, урт хугацааны мөнгөн хөрөнгийн төлөвлөлттэй уялдуулан валютын форвард, своп хэлцлүүд хийн, багц бүтээгдэхүүний оновчлолыг сайжруулах замаар үйлдвэрлэлийн тасалдлаас урьдчилан сэргийлж бизнесийн ашигт ажиллагааг ханган үнэ цэнийг түгээж чадсан.

Харин дотоод эх үүсвэртэй эрсдэлүүдийн хувьд стратеги, үйл ажиллагаа, санхүү, нийцлийн үр дагавраас хамааруулан холбогдох алба нэгжүүдийн оролцоотойгоор эрсдэлүүдийг тодорхойлж, тэдгээрт нарийвчилсан дүн шинжилгээ хийн, эрсдэлийг оновчтой үнэлж, зэрэглэн, зохимжит түвшинд эрсдэлийг барих, эрсдэлийг бууруулах ажлын гүйцэтгэлийн түвшинд мөшгөлт хийх замаар эрсдэлийг удирдан ажиллаж байна.

ГАДААД ХҮЧИН ЗҮЙЛСИЙН НӨЛӨӨЛӨЛ БА ТОМООХОН ЭРСДЭЛҮҮД



Цаг уурын өөрчлөлт, байгалийн давагдашгүй хүчин зүйл	Эдийн засгийн тодорхойгүй байдал, ашиг орлого	Шинэчилсэн хуулийн шаардлага, нийцэл	Геополитикийн сөргөлдөөн	Мэдээллийн оновчтой бус урсгал, нэр хүндийн эрсдэл

★ **Боломж**
 ○ **Дам нөлөө**
 ○ **Шууд нөлөө**

ҮРГЭЛЖ ӨӨДӨӨ ALWAYS FORWARD

2023 ОНОО ДҮГНЭХ НЬ:

АПУ ХК 2023 онд “Бахархалт Монгол” тогтвортой хөгжлийн стратегийн хүрээнд нийгэм, байгаль орчин болон засаглалд чиглэсэн томоохон төсөл хөтөлбөрүүдийг санаачлан хэрэгжүүлэхийг зорилго. Бид итгэл үнэмшлээ даган алсын хараагаа “**Дэлхийд танигдах эрхэм монгол хүмүүний оюун чадвар, ур ухаан, шинэчлэл, тогтвортой хөгжлийн ундарга байя**” гэж шинэчилсэн бөгөөд 100 дахь жилээ угтаж буй АПУ ХК цаашдын нөлөөллөө хэрхэн харж буйн тод илрэл юм.

Монгол улсын хамгийн том өв бол бид, Монгол түмэн өөрсдөө билээ. Тийм учраас алхам тутамдаа эх дэлхий болон өрөөл бусдыгаа тэтгэж, уялдан нэгдэж ирсэн энэ амьдралын хэв маягаараа бахархаж, тогтвортой байдалд ач холбогдол өгөх нь зүйтэй.

2024 ондоо стратегиа үргэлжлүүлэн сайжруулж, групп компанийн хэмжээнд улам илүү нөлөө бүхий ажлуудыг хариуцлагатайгаар хэрэгжүүлэхийг хичээн ажиллах болно.

